



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 05 дугаар
сарын 11-ны өдөр

Дугаар ... ХТ/2260

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ОДОНТУЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 6/ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021507278

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн
дугаар албан бичгийн хавсралт



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ОДОНТУЯАГААС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албаны тухай хууль зэрэг цэргийн албаны үйл ажиллагаанд баримталдаг хууль, тогтоомжуудын хяналт шинжилгээ, хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.

Монгол Улсын батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор “Монгол Улсын батлан хамгаалахын бодлогын үндэс” баримт бичиг, 2016 онд батлан хамгаалахын багц хууль /Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль/-ийг Улсын Их Хурлаас тус тус баталсан.

Батлан хамгаалахын багц хууль батлагдсанаар Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндэс шинэчлэгдэж, төрийн цэргийн байгууллын тогтолцоо, Зэвсэгт хүчний бүтэц шинээр тодорхойлогдож, Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар хүлээсэн цэргийн алба хаах үүргээ биелүүлэхтэй холбоотой асуудлууд тодорхой болж, цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын зохицуулалт дээшилсэн.

Төрийн батлан хамгаалах бодлого, багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Орон нутгийн хамгаалалтын тухай, Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг 7 хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Түүнчлэн, Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоолоор “Төрийн цэргийн байгууллын хөгжлийн стратеги-2030” баримт бичиг, Засгийн газрын 2017 оны 80 дугаар тогтоолоор “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус баталсан бөгөөд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Батлан хамгаалахын сайдын 2021 оны н/дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг боловсронгуй болгох, цэргийн албаны болон цэргийн алба хаагчдын эрх зүйн харилцааг нарийвчлан журамласан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан 101 баримт бичиг мөрдөгдөж байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 9, Засгийн газрын тогтоолоор 21, Батлан хамгаалахын сайдын тушаалаар 31, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар 40 баримт бичгүүд батлагдсан байна.

Мөн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын баталсан “Цэргийн албыг зохион байгуулах заавар” баримт

бичгүүд, бусад хууль тогтоомж, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн заавраар зохицуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/375 дугаар тушаалаар баталсан "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам", ЗХЖШ-ын даргын 2020 оны А/118 дугаар тушаалаар баталсан "Зэвсэгт хүчинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг баримтлан батлан хамгаалахын салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж байна.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 2 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу Монгол Улсын батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ болон хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр Батлан хамгаалах яам Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллаж байгааг мэдээлэл болгон хүргүүлж байна.

Асуулга 2. 2010 оноос өнөөг хүртэл батлан хамгаалах салбарын хэмжээнд хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан гэмт хэргийн тухай нэгтгэсэн мэдээлэл болон хохирлыг хэрхэн барагдуулж, хариуцлага тооцсон тухай мэдээ тайлан.

Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг Цэргийн хэрэг бүртгэх алба хэрэгжүүлж байгаад 2000-аад оноос өмнө татан буугдсан бөгөөд түүнээс хойш цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэргийн нэгдсэн мэдээлэл, судалгааг гаргахад бэрхшээлтэй болсон. Тухайлбал, Зэвсэгт хүчинд бүртгэгдээгүй, өөрөөр хэлбэл, цэргийн алба хаагч цэргийн анги, байрлалаас гадна нийгмийн харилцаанд иргэний хувьд оролцож байхдаа үйлдсэн гэмт хэргүүд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгддэг процессын онцлогоос хамаарч дүн бүртгэл зөрүүтэй гардаг. Тухайлбал, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн цэргийн алба хаагчийн холбогдсон зарим хэрэг прокурор, шүүхийн шатанд хэрэгсэхгүй болдог. Ийм нөхцөл байдал бий болсон тул 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гарган ажиллаж байна.


Зэвсэгт хүчинд 2011-2020 онд бүртгэгдсэн гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, тархалтыг тодорхойлж, гэмт хэргийн улмаас үүссэн хор хохирлыг тодорхойлон гаргаж, дүн шинжилгээ хийсэн.

Зэвсэгт хүчний 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаанаас харахад, тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 оноос хойш буурах үзүүлэлт гарсан. Сүүлийн 10 жилийн хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 54, жилд дунджаар 5 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт гэмт хэрэгт 78 цэргийн алба хаагч холбогдон шалгагдсан статистик мэдээ байна.

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	2	2	1	4	2	2	5	5	18	13	54
2	Өсөлт, бууралт /хувиар/	-33,3	0	-50	400	-50	0	250	0	360	-27,7	
3	Холбогдсон	3	2	1	4	4	2	5	7	20	17	65

	хүний тоо											
4	Өсөлт, бууралт /хувиар/	0	-33,3	-50	400	0	-50	250	40	285	-15	

График-1.1 Гэмт хэргийн байдал



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 2011-2020 онд 12 төрлийн 78 холбогдогчтой 54 эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдэж, шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

Гэмт хэргийн төрөл	2011 ОН	2012 ОН	2013 ОН	2014 ОН	2015 ОН	2016 ОН	2017 ОН	2018 ОН	2019 ОН	2020 ОН
Анги, байрлалаа орхин оргон зайлсан	1	1								1
Хүний амь нас хохирсон	1		1		2				1	
Галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбоотой		1				1				
Бусдын бие махбодод гэмтэл учруулсан				4		1	2	2	2	4
Амиа хорлохыг завдсан							3			
Албан тушаалаа урвуулан ашигласан								1	1	
Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн								2	3	3
Хүчиндэх									3	
Дээрэм									1	
Хууль бус ан агнах									3	
Хулгай									2	4
Цэргийн албаны эсрэг									2	1

Дээрх гэмт хэргүүдийн 5.5 хувь нь анги, байрлалаа орхин оргон зайлах, 9.2 хувь нь хүний амь нас хохироосон, 3.7 хувь нь галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбогдсон, 27.7 хувь нь бусдын бие махбодод гэмтэл учруулах, 5.5 хувь нь амиа хорлохыг

завдсан, 3.7 хувь нь албан тушаалаа урвуулан ашигласан, 14.8 хувь нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн, 5.5 хувь нь хүчиндэх, 1.8 хувь нь дээрэм, 5.5 хувь нь хууль бус ан агнах, 11.1 хувь нь хулгай, 5.5 хувь нь цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

Гэмт хэргийн өсөлт, бууралт нь криминологийн үүднээс авч үзвэл, олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд Зэвсэгт хүчний дотоод хяналт, шалгалт сайжирч, нуугдмал гэмт хэргүүд илрэх, хууль эрх зүйн өөрчлөлттэй холбоотойгоор гэмт хэрэгт шинээр тооцох эсхүл гэмт хэрэг биш болох, гэмт хэрэг, сахилга дэг журмыг сайжруулах хүрээнд зохиогдож байгаа ажил, арга хэмжээний үр дүн, цаг үеийн хүчин зүйл /цаг тахлын хөл хорионы дэглэмээс үүдэлтэй нийгмийн сэтгэл зүйн бухимдал, стресс гэх мэт/-тэй холбоотой юм.

Зэвсэгт хүчний хэмжээнд гарсан гэмт хэрэг, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдолтой осол, зөрчлийг Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар хариуцан, дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гарсан осол, зөрчлийг судлан бүртгэдэг.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол 90 тохиолдол бүртгэгдсэнээс, 48 хүн хөнгөн, 30 хүн хүндэвтэр гэмтэл авч, 12 хүн нас барсан /усанд живсэн-8, РГД-5 гранат тэсэрснээс-2, авто осол-2/ байна. Үүнийг тухайн ослын шинж чанараар нь авч үзвэл дараах хүснэгтэд заасан байдалтай байна.

№	Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол	Хөнгөн	Хүндэвтэр	Амт насаа алдсан
1	Санамсар болгоомжгүйгээс унах, бүдрэх, халтирах	19	3	
2	Эд зүйлд цохигдох, хавчуулагдах, дарагдах	10	5	
3	Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн хийсний улмаас	6	3	
4	Галт зэвсэг, галт хэрэглэл, хортой бодистой буруу харьцах	4	15	2
5	Авто осолд орсон		4	2
6	Усанд живсэн			8
7	Бусад	9		
Дүн		48	30	12
Нийт			90	

2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас 8 хүн, 2020 онд 20 хүн бэртэж гэмтэн, хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдсан байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар хүний амь эрсэдсэн гэмт хэрэг, осол, зөрчлийг авч үзэхэд, 2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг 1, гэмт хэргийн шинжтэй үйлдэл 3 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 1 цэргийн алба хаагч нас барсан бөгөөд тухайн хэргүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шалгуулсан байна. Түүнчлэн, Зэвсэгт хүчний хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 2, авто ослоор 2, золгүй байдлаар /амиа хорлосон, өвчний улмаас/ 2 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан байна.

2020 онд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргийн улмаас нас барсан цэргийн алба хаагч байхгүй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 4

/усанд живсэн/, авто ослоор 3, золгүй байдлаар /амиа хорлосон, авто осол, өвчний улмаас/ 6 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан.

2021 оны эхний улирлын байдлаар, Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хөдөлмөрийн аюулгүй байдлын осол 2 удаа гарч, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой ослоор нас барсан цэргийн алба хаагч байхгүй. Цэргийн алба хаагчид нийгмийн харилцаанд оролцохдоо гаргасан зөрчил, иргэний хэргийн талаарх мэдээлэл Зэвсэгт хүчинд байхгүй. Дүрмийн бус харилцааны асуудлаас 1 хугацаат цэргийн алба хаагч нас барсан. Энэхүү хэрэгт холбогдсон офицер хууль, хяналтын байгууллагаар шалгагдаж байна.

Сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн, Зэвсэгт хүчний гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлийн үзүүлэлтээр цаашдын чиг хандлагыг тодорхойлоход гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд нуугдмал гэмт хэргүүд илэрч өсөх хандлагатай байна. Зэвсэгт хүчний хэмжээнд гарсан гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлүүдэд дүгнэлт хийхэд цэргийн албанд хамааралтай дараах үндсэн шалтгаан, нөхцөлөөс үүдэлтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Нэгтгэл, анги, салбарт “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бусад удирдлагын баримт бичгүүдийг судлах, сурталчлах, хэрэгжүүлэх ажил хангалтгүй;

2. Зарим албан тушаалтны ажлын хариуцлага, санаачилга сул, цаг үеэ мэдэрч хандлага, сэтгэлгээгээ өөрчлөхгүй урсгалаар ажиллах, цэргийн алба хаагчдын хууль тогтоомж, дүрмийн мэдлэг дутмаг;

3. Залуу офицер, ахлагч нарыг хүнтэй ажиллах арга барилд сурган дадлагажуулах ажил бүрэн хэрэгждэггүй, тэдний ар гэр амьдрал ахуйг нарийвчлан судлах, тэдэнд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил дутмаг;

4. Цэргийн хангалт үйлчилгээг заавар, журмын дагуу зохион байгуулах асуудал дутагдалтай /санхүүгийн боломжоос шалтгаалдаг/;

5. Цэргийн албанд сахилга дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй цэргийн цагдаагийн салбар нэгжүүдийн үйл ажиллагааны эрх орчин бүрдээгүй, үйл ажиллагаа нь тогтмолжоогүй зэрэг болно.

Зэвсэгт хүчинд сахилга, дэг журам сахиулах, гэм хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй цэргийн цагдаагийн нэгжийг богино хугацаанд бэхжүүлэх зорилго тавьж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд цэргийн албанд бүртгэгдсэн гэмт хэргүүдийг хууль, хяналтын байгууллагын дүн бүртгэлтэй харьцуулж мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, судалгаа шинжилгээ хийж шалтгаан нөхцөлийг тодорхойлох, хариу ажил, арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах бодлогын хүрээнд Зэвсэгт хүчний цэргийн цагдаагийн албыг бэхжүүлэх, шуурхай удирдлага, зохицуулалт, мэдээллийн тогтолцоог бий болгох эрх зүй орчныг бүрдүүлэх чиглэлээр “Цэргийн цагдаа-2030” хөгжлийн хөтөлбөрийг 2021 оны 1 дүгээр сард баталж, цэргийн цагдаагийн бүлгүүдийг түшиглэн цэргийн хүрээ, хотхон бүрт цэргийн цагдаагийн 16 салбар, нэгжийг байгуулах шийдвэрийг 2021 оны 3 дугаар сард гаргаж “Цэргийн нийтлэг дүрмүүд”-д өөрчлөлт оруулах санал болон “Цэргийн цагдаагийн ажиллагааны журам”-ыг шинээр боловсруулсан.

Зэвсэгт хүчинд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ, судалгааг цагдаа,

хууль хяналтын бусад байгууллагын мэдээлэлтэй харьцуулах, нэгдсэн сан бүрдүүлэх зорилгоор ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргаас 2021 оны 4 сарын 15-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандан 2010-2021 оны хооронд гэмт хэрэг үйлдэж яллах дүгнэлт үйлдэгдэн шүүхэд шилжсэн, хэрэгсэхгүй болсон, ял шийтгэгдсэн цэргийн алба хаагчдын мэдээлэл, судалгааг ирүүлэхийг хүссэн албан бичиг хүргүүлж, хамтран ажиллаж байна.

Нөхөн олговрын талаар:

Цэргийн алба хаагч нас барсан тохиолдолд ар гэрт нь нөхөн олговор олгох харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу зохицуулж байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт "Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т заасан шалтгаан /байлдааны талбар, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, байлдааны галт хэрэгслээр буудлага хийх, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах, гамшиг, онцгой нөхцөлийн байдалд ажиллах, улсын хил, онц чухал объектыг хамгаалсны улмаас/-аар амь насаа алдвал 10 жилийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан шалтгаан /энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас/-аар амь насаа алдвал 5 жилийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаан /албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, тарилгын дараах хүндрэл, ердийн өвчний улмаас/-аар амь насаа алдвал 3 жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын цалин хөлсний дунджаар, хэрэв байлдагч, түрүүч, цэргийн үүрэгтэн амь насаа алдсан бол ахлагчийн сарын цалин хөлсний дунджаар тооцож тэдний ар гэрт нэг удаа олгоно." гэж заасан байдаг.

Энэхүү хуулийн зохицуулалтын дагуу ослоор нас барсан цэргийн алба хаагчдын ар гэрт нь ЗХЖШ-ын даргын тушаалаар нэг удаагийн тэтгэмж олгож ирсэн. Үүнийг сүүлийн 4 жилийн байдлаар харуулбал:

№	Цэргийн алба хаагч	Тэтгэмжийн хэмжээ /төгрөг/	Төрөл	Шалтгаан
2017 онд				
1	Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ахмад Б.Мөнгөншагайн ар гэрт	99,218,160	Нэг удаагийн тэтгэмж	Осол
2	Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ахлагч Б.Ариунболдын ар гэрт	65,713,440	Нэг удаагийн тэтгэмж	Осол
2018 онд				
3	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахлах ахлагч С.Мөнхжаргалын ар гэрт	41,701,078	Нэг удаагийн тэтгэмж	Усанд живсэн
4	Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн сургагч ахлагч Ч.Энхтуяагийн ар гэрт	28,219,968	Нэг удаагийн тэтгэмж	Ухаан алдаж зуурдаар нас барсан
2019 онд				

5	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байлдагч Б.Алтантулгын ар гэрт	30,152,760	Нэг удаагийн тэтгэмж	Ангийн сургалтын төвд гүйх явцад бие нь муудаж нас барсан
		1,000,000	Оршуулгын зардал	
6	Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн ахлах ахлагч Я.Ганболдын ар гэрт	48,358,843	Нэг удаагийн тэтгэмж	Автомашинд дайрагдан нас барсан
		1,000,000	Оршуулгын зардал	
7	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн байлдагч Б.Наранбаярын ар гэрт	30,152,760	Нэг удаагийн тэтгэмж	Автомашин тэвшнээс унаж, автомашины чиргүүлд дайрагдаж, нас барсан
		1,000,000	Оршуулгын зардал	
8	Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн энгийн Х.Төмөрбаатарын ар гэрт	1,000,000	Оршуулгын зардал	Ээлжинд үүргээ гүйцэтгэх үедээ зүрхний шигдээс өвчнөөр нас барсан
9	Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн ахлах ахлагч П.Тэгшжаргалын ар гэрт	1,000,000	Оршуулгын зардал	Амиа хорлосон
10	Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн ахмад Г.Тамирын ар гэрт	62,834,337	Нэг удаагийн тэтгэмж	Автомашин осол
2020 онд				
11	Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн цэргийн гэрээт албаны байлдагч С.Алтанбаганын ар гэрт	39,838,680	Нэг удаагийн тэтгэмж	Усанд живсэн
12	Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн ахлагч Г.Гантулгын ар гэрт	22,576,392	Нэг удаагийн тэтгэмж	Усанд живсэн
13	Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн дэд ахлагч Ж.Анар-Эрдэнийн ар гэрт	23,711,472	Нэг удаагийн тэтгэмж	Усанд живсэн
14	Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн дэд ахлагч Б.Батзоригийн ар гэрт	25,175,556	Нэг удаагийн тэтгэмж	Усанд живсэн
Нийт		552,653,446		

Сахилгын хариуцлага, шийтгэл:

2020 онд албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан удирдлагын байгууллагын 9 офицер, 1 ахлагч, нийт 10 хүн, нэгтгэл, анги, байгууллагад 928 офицер, 1690 ахлагч, 13 цэргийн гэрээт алба хаагч, 30 хугацаат цэргийн алба хаагч, 342 ажилчин албан хаагч, нийт 3003 хүнд "Цэргийн сахилгын

дүрэм"-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан байна.

2021 оны эхний улирлын байдлаар хугацаат цэргийн алба хаагчдаас болон ар гэрээс мөнгө авч байгаа талаар иргэдээс 2 өргөдлийг хүлээн авч, дотоод хяналт шалгалтыг хийж, холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл оногдуулсан байна. Хугацаат цэргийн алба хаагчдаас болон ар гэрээс мөнгө авч байгаа талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авч, шалгах үйл ажиллагаа үргэлжилж байна.

2021 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байлдагч Ц.Батгэрэл хүнд гэмтэл авсны улмаас нас барсан жергийг шалгах явцад тус ангийн ахлагч И.Энхтөгс хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрээс өөрийн эзэмшлийн дансаар мөнгө шилжүүлэн авдаг байсан зөрчлийг илрүүлэн, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Албаны шалгалтын хүрээнд хийгдсэн санал асуулга, судалгааны дүнгээс харахад цэргийн алба хаагчдын ар гэрийн зүгээс өөрсдөө Зэвсэгт хүчний анги, салбарын офицер, ахлагч нартай холбогдон мөнгө, төгрөг шилжүүлж байсан нь тогтоогдсон. Энэ нь Цэргийн дотоод албаны дүрэм, офицер, ахлагчийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл юм.

Тухайн гэмт хэрэг үйлдсэн Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы салааны захирагч дэслэгч Д.Гялбуужамц нь хууль, шүүхийн байгууллагаар шалгагдаад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Дээрх хэрэгтэй холбогдуулан ЗХЖШ-ын дарга хууль, дүрэмд заасан эрх мэдлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Дүрмийн бус зөрчил гарсантай холбогдуулан ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/360 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагч хурандаа С.Батболдыг албан тушаал болон цэргийн жинхэнэ албанаас нь чөлөөлж, цэргийн тэтгэвэрт гаргасан.

ЗХЖШ-ын даргын удирдамж, шийдвэрээр Зэвсэгт хүчний Хяналт- шинжилгээ, үнэлгээний газраас томилогдсон албан тушаалтнууд 03 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 326 дугаар ангид төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулж, танилцуулгыг ЗХЖШ-ын даргын зөвлөлийн 2021 оны 04 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж дараах албан тушаалтнуудад хариуцлага тооцохоор шийдвэрлэсэн.

1. Харьяа анги, байгууллагад нь ноцтой зөрчил гарч хугацаат цэргийн амь нас хохирсон, албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Б.Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга бригадын генерал Л.Онцгойбаяр нарыг ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/388 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан "Цэргийн сахилгын дүрэм"-ийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг үндэслэн сануулж шийтгэсэн.

2. Дэслэгч Д.Гялбуужамцын өмнөх дүрмийн бус харьцааны зөрчилтэй холбогдуулан цэргийн албанаас халах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Хүний нөөцийн хэлтсийн дарга хурандаа Д.Энхсайханыг ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/386 дугаар тушаалаар албан тушаалаас нь чөлөөлсөн.

3. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан зорилго, зорилт, үндсэн чиг үүргээ ханган ажиллаагүй, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын даргыг албан ажилтай байх үед нь түүнийг орлон ажиллаж байсан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа

О.Эрдэнэбаатарыг албан тушаалаас нь чөлөөлсөн.

4. Дүрмийн бус харьцааны зөрчил гарсан өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хариуцлагатай эргүүлээр үүрэг гүйцэтгэхдээ харуул, хоногийн манааны бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллаагүй тус ангийн ахлагч, тэргүүн ахлагч Б.Нямбаярыг ЗХЖШ-ын даргын 2021 оны 6/385 дугаар тушаалаар албан тушаал болон цэргийн жинхэнэ албанаас нь чөлөөлж, цэргийн тэтгэвэрт гаргасан.

5. Ангийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж байсан Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Химийн албаны дарга ахмад Ө.Тэмүүжин, Шалган нэвтрүүлэх байрны жижүүрийн үүрэг гүйцэтгэж байсан Үлээвэр найрал хөгжмийн салааны хөгжимчин ахлагч Д.Отгонбаяр нарыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн 2021 оны 6/117, 6/118 дугаар тушаалуудаар албан тушаалаас нь чөлөөлж, цэргийн жинхэнэ албанаас халсан.

6. Хэрэг болох үед хамт байсан боловч дүрмийн бус харьцааны зөрчлийг таслан зогсоогоогүй салааны захирагч дэслэгч Э.Анхбаяр, хохирогч байлдагч болон бусад байлдагч нарын ар гэрээс өөрийн дансанд мөнгө шилжүүлэн авч байсан дивизионы ахлагч сургагч ахлагч Э.Энхтөгс нарыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн 2021 оны 6/116 дугаар тушаалаар албан тушаалаас нь чөлөөлж, цэргийн жинхэнэ албанаас халж, хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн.

7. Хариуцсан салаа, салбарын офицер, ахлагч нарын өдөр тутмын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлт болон цэргийн алба, сахилга зохион байгуулалтад хяналт тавьж ажиллаагүйн улмаас цэргийн алба хаагчдын хооронд харьцааны зөрчил үүсэх, ар гэрээс нь мөнгө авах нөхцөлийг бүрдүүлсэн Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенит артиллерийн дивизионы захирагч дэд хурандаа Г.Сансар-Эрдэнэ, Зенит артиллерийн батарейны захирагч ахмад Б.Гунгаажанцан нарыг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн 2021 оны 6/115 дугаар тушаалаар “Албан тушаалдаа дүүрэн тэнцэхгүй байгааг сануулж” шийтгэсэн.

Асуулга 3. Цэрэгт татагдаж буй залуусын мэдлэг, соёл, хандлага өөрчлөгдөхийн хэрээр цэргийн номлол болон тогтолцоонд шинэчлэл хийх шаардлагатай. Дээрх зүй бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний богино болон урт хугацааны төлөвлөгөө, тухайлбал, салбарын эрх зүйн орчин, дүрэм журмын нэмэлт өөрчлөлтүүдийн тухай мэдээлэл.

Монгол Улсын Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарыг Үндэсний батлан хамгаалахын их сургууль болон гадаадын цэргийн академи, их, дээд сургуульд бэлтгэн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт томилон ажиллуулдаг.

Өнөөдрийн байдлаар ҮБХИС нь сонсогчдыг 2+2 хөтөлбөрөөр Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд шаардлагатай офицерын бүрэлдэхүүнийг бэлтгэж байгаа хэдий ч нэгтгэл, анги, байгууллагад ажиллах офицерт тавигдах шаардлагыг бүрэн хангахгүй байгаа тул 2022-2023 оны хичээлийн жилээс тус сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг академик сургалттай урьд хэрэгжүүлж байсан уламжлалт тогтолцоонд шилжүүлж, 4 жилийн цэргийн сургалтаар салаа, салбарт ажиллах мэдлэг, чадвартай офицеруудыг бэлтгэн гаргахаар төлөвлөөд байна.

Түүнээс гадна хугацаат, цэргийн албанд татагдагч цэргийн насны залуучуудын төлөвшил, үзэл бодол, сэтгэлгээ нь цэргийн хөдөлмөрийн онцлогтой зөрчилдөж, хувь хүний зан чанарын онцлог зэргээс шалтгаалан цэргийн албанаас шантрах,

цэргийн алба хаагчийн эрх зөрчигдөх, сахилга дэг журмын зөрчил, гэмт хэрэгт холбогдогчийн тоо буурахгүй байна.

Зэвсэгт хүчний Жанжин штаб дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж, цэргийн албаны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбарт бэхжүүлэх талаар онцгойлон анхаарч Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн н/40 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд “Цэргийн албаны хэлтэс”-ийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Уг зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагаа бүрэн жигдэрснээр цэргийн албанд ёс зүй, сахилга дэг журмыг сахиулах, бэхжүүлэх, цэргийн албаны гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, бие бүрэлдэхүүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын чадавх нэмэгдэнэ.

БХЯ болон ЗХЖШ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл” Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 23 дугаар зарлигаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн зөвлөмж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд”, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/335, А/336, ЗХЖШ-ын даргын 2017 оны А/535 дугаар тушаал, даалгавар, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, архи дан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, осол, сахилгын зөрчилд дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг, чиглэлийг ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад тухай бүрд нь хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, цэргийн алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх шинэчлэлийг эхлүүлж, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийг байгуулж, “Иргэний зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулж үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. /Журмыг хавсаргав./ Батлан хамгаалахын сайдын дэргэд “Иргэний зөвлөл” байгуулагдсанаар Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын тогтолцоо бүрдэж, ард, олон нийтийн хяналт сайжирч, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нийгэмд илүү нээлттэй болно гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд цэргийн нэгтгэл, ангийн байрлалд, цэргийн алба хаагчдын дунд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил болон хууль, дүрмийн бус харьцаа, үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрсдэх, эрүүл мэндээр хохирох асуудал буурахгүй байгаа бөгөөд үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь архидалт, согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой болох нь шат шатны байгууллагын хяналт шалгалтын үнэлгээ, дүгнэлтээс харагдаж байгаа юм.

Түүнчлэн, цэргийн алба хаагчид цэргийн албаны болон сургалт, бэлтгэлийн онцлогтой уялдуулан зэвсэг, байлдааны техник, хэрэгсэлтэй харьцдагаас архи, согтууруулах ундааны зүйл, хэрэглэсэн үед үйлдэгдэх гэмт хэргийн улмаас хүний амь нас эрсдэх эрсдэлийг бий болгож байна.

Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтаар хязгаарлаж, хориглосон хэдий ч хариуцлага тооцох хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс дээрх хэрэг, зөрчил буурахгүй байна.

Иймд цэргийн алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байхдаа архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай" /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлд тусгах санал болон түүнийг дагалдан гарахаар Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулж Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хүргүүлсэн. Тус нэмэлтээр Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд төрийн албанд хоёр жилийн хугацаанд эргэж орох нөхцөлгүйгээр халах хариуцлагын асуудлыг тусгасан. /Хуулийн төслийг хүргүүлсэн албан бичгийг хавсаргав./

Түүнчлэн Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж байгууллагад архи дан согтуурахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс Батлан хамгаалахын сайдын 2021 оны "Архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" А/83 дугаар тушаалыг батлан, салбарын хэмжээнд мөрдөж эхлээд байна. /Тушаалын хуулбарыг хавсаргав./

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сэтгэл зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилоод байна. Үүнтэй зэрэгцүүлэн сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах, төрийн албан хаагчийн ёс зүйг өндөржүүлэхийн тулд Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар, ёс зүйн түвшинг тогтоох үзлэг явуулахаар холбогдох шийдвэрүүдийг гаргаад байна. /Тушаалын хуулбарыг хавсаргав./

Зэвсэгт хүчний хэмжээнд гарсан гэмт хэрэг, осол, сахилгын зөрчлийн судалгааны нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар 2021 он гарснаас хойш 4 албан даалгавар, 1 зөвлөмж, 1 сэрэмжлүүлэг, 3 акт, 1 танилцуулга, 1 үлгэрчилсэн аргачлалыг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллаж байгаа юм.

ЗХЖШ-ын удирдлагаас 2021 оны 03 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын залуу офицеруудын төлөөлөлтэй, 03 дугаар сарын 17-нд даргалах албан тушаалын ахлагч нартай "Цэргийн алба, сахилга хариуцлага"-ын талаар цахимаар тус тус уулзаж үүрэг, даалгавар, зөвлөмж өгсөн. Уг уулзалтад Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын 200 гаруй залуу офицер, 354 даргалах албан тушаалын ахлагч нар оролцсон.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт далд хэлбэрээр байж болзошгүй сахилгын болон харилцааны зөрчлийг илрүүлэх, бие бүрэлдэхүүний албандаа хандах хандлага, санал хүсэлтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргын 2021 оны 3/2626 дугаар албан даалгаврын дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас социологийн судалгааг 03 дугаар сарын 29-нөөс

30-ны өдрүүдэд нэгдсэн журмаар авч, үнэлэлт, дүгнэлт өгсөн. Судалгаанд Зэвсэгт хүчний 39 нэгтгэл, ангийн офицер 756, ахлагч 1760, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч 2626, нийт 5142 цэргийн алба хаагч хамрагдсан. Судалгааг тухайн агуулга, зорилгод нийцсэн 17 асуултаар сорил авсан бөгөөд хамрагдсан бүрэлдэхүүний 69,5 хувийг Зэвсэгт хүчинд 1-10 жил алба хааж байгаа залуучууд эзэлж байгаа нь судалгааны дүнд залуучуудын үзэл бодол, итгэл үнэмшил түлхүү тусгагдсан гэж үзэж болно. Цаашид судалгааны хүрээнд илэрхийлэгдсэн санал, хүсэлтийг нарийвчлан судалж даруй хэрэгжүүлэх арга хэмжээг ангилан, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг үе шаттай төлөвлөн ажиллах болно.

“Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар ажиллаж эхэллээ. Энэхүү тусгай дугаараар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, салбартай холбоотой аливаа мэдээллийг нээлттэй, 24 цагийн турш хүлээн авснаар батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой иргэдийн санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломж бүрдсэн. Мөн цэргийн алба хаагчдын дүрмийн бус харьцааг илрүүлэх, цэргийн алба, сахилга дэг журмын талаар ард иргэд болон цэргийн алба хаагчдаас гомдол, мэдээлэл авах бөгөөд мэдээлэл гаргагчийн нууцлалыг хадгалах юм.

Хугацаат цэргийн алба хаагчийн сэтгэл зүйг тогтвортой байлгах, ар гэртэй нь чөлөөтэй холбоо бариулах зорилгоор тусгай журам боловсруулж мөрдүүлж эхэлсэн бөгөөд хугацаат цэргийн алба хаагч ар гэрээсээ эргэлт авах, ар гэрийнхээ хүмүүстэйгээ уулзах боломж хязгаарлагдмал тул алба хаагчийн хувийн хэрэгцээний зүйлийг илгээмжээр хүлээн авахыг журамлах ажил хэрэгжиж байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний ангиудад шаардлагатай хяналтын камер болон дагалдах хэрэгслийн судалгаа, тооцоог гаргаж, эхний ээлжинд хугацаат цэргийн алба хаагчидтай Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг камержуулах ажлыг 2021 оны II улиралд багтаан зохион байгуулах шийдвэрийг гарган ажиллаж байна. /Тушаалын хуулбарыг хавсаргав./

БХЯ, ЗХЖШ-удирдлагаас хамтран Төрлийн цэргийн командлалууд Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын сэтгэл зүйн хангалт хариуцсан албан тушаалтнуудтай нэгдсэн зөвлөгөөнийг 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж офицеруудын боловсрол, цэргийн хэргийн мэдлэг, цэргийг сургаж хүмүүжүүлэх, удирдах чадвар, ажлын арга барил, хариуцлагаас Зэвсэгт хүчний өмнөө тавьж буй зорилго, зорилт, үүргийн хэрэгжилт, амжилт, нэр хүнд шууд хамаардаг учир хугацаат цэргийн алба хаагчидтай ажиллаж байгаа залуу офицеруудын хүнтэй ажиллах арга барилыг сайжруулахад цэргийн сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн офицеруудын үүрэг, оролцоо асар их байгаа талаар зөвлөлдөв. Зөвлөгөөнөөс гарсан санал, ЗХЖШ-ын даргын хүргүүлсэн “Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөх нь мөрдөстэй бүхний үүрэг” уриалгыг ажил албандаа хэрэгжүүлэх ажил зохион байгуулагдаж байна.

2015 онд Засгийн газрын шийдвэрээр “Зэвсэгт хүчний ном, соёлын арга хэмжээний зардал” буюу сэтгэл зүйн хангалтыг сайжруулах төсвийг тэвчиж болох зардалд тооцож хассан нь цэргийн сэтгэл зүйчдээ мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах боломжийг хязгаарлаж байна.

ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтэс, Сургалтын бодлого зохицуулалтын хэлтэстэй хамтарч Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бие бүрэлдэхүүнтэй явуулах “**Цэргийн алба хаагчийн хөгжил-нийгмийн хариуцлага**” сургалтын хөтөлбөр боловсруулж цэргийн алба хаагчаас албандаа хандах шинэ хандлага, эрх

зүйн ухамсрыг дээшлүүлэх, алба хаагчдын гэр бүл төлөвлөлт, эрүүл мэнд, санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ажлын байран дахь хамтын ажиллагаа ба ёс зүйн итгэл үнэмшлийг бий болгох, цаг үеийн өөрчлөлт, мэдээлэл, технологийн өндөр хурд, ачаалалтай нийгмийн харилцааны онцлог энэ цаг үед харилцааны ёс зүй, стресс менежментийн мэдлэг олгож, улмаар ажил, амьдралын зөв дадалтай болгоход чиглэсэн сургалтыг 5 дугаар сарын эхний 7 хоногоос эхлэн нэгтгэл анги, салбаруудад хуваарийн дагуу явуулахаар бэлтгэл хангагдаад байна.

Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн цэргийн байгууллын хөгжлийн стратеги-2030" болон "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" зэрэг бодлогын баримт бичигт тусгалаа олсон цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шинэчлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгын хүрээнд төлөвлөн хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн УИХ-ын хүний эрхийн дэд хорооны хуралдаанаас гарсан зөвлөмж, чиглэлийг тусган "Зөв иргэн-шинэ үеийн цэрэг хамтын хөгжил" дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. /хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг хавсаргав./

ЗХЖШ-аас Цагдаагийн ерөнхий газартай гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн төслийг боловсруулж санал авахаар хүргүүлсэн. /Санамж бичгийн төслийг хавсаргав/

Мөн Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолын дагуу "Зэвсэгт хүчинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г ЗХЖШ-ын дарга батлан хэрэгжүүлж байна. /Төлөвлөгөөг хавсаргав./

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Нэг. Бодлогын түвшинд:

- Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цэргийн албаны болон цэргийн алба хаагчийн, ялангуяа хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

- Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх;

- "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд ерөнхий боловсролын дунд сургуулиудтай хамтран ажиллах;

- Бие бүрэлдэхүүний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цэргийн алба хаагчдын хандлагыг өөрчлөн, бие биедээ хүндэтгэлтэй ханддаг байх харилцааг төлөвшүүлэх;

- Цэргийн нэгтгэл, ангийн камерын хяналтын системийг бүрдүүлэх;

- Цэргийн нэгтгэл, ангийг архигүй орчин болгож, цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх асуудлыг таслан зогсоох.

Хоёр. Үйл ажиллагааны түвшинд:

- Цэргийн сургалтын хөтөлбөр, сургалтын тогтолцоо, арга хэлбэр, технологийг өөрчлөн цэргийн сургалт, цэргийн алба, цэргийн хүмүүжлийн асуудлын

харилцан хамаарлыг зүй зохистойгоор нягт уялдуулах, залуу офицер, ахлагч нарын зан байдал, төлөвшил, харилцааны ёс суртахуунд онцгой анхаарах;

- Цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх судалгаа, бодит үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлэх;

- Цэргийн алба хаагчдыг гэмт хэрэг, сахилгын аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, санамжийг байнга өгч, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын дотоод хяналт шалгалт, шалган зааварлах үйл ажиллагааг үр дүнтэй, дэвшилтэт арга механизмыг бүрдүүлэх замаар Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг, сахилгын зөрчлийг бууруулах, таслан зогсоох;


- Цэргийн цагдаагийн үйл ажиллагааг жигдрүүлэх, улмаар цэргийн цагдаагийн шуурхай удирдлага, зохицуулалтын тогтолцоог бий болгох;

- Бүх шатанд хүний эрхийн зөрчил, хүнлэг бус харьцааг гаргуулахгүй байх, энэ төрлийн зөрчил илэрсэн тохиолдолд нэн яаралтай таслан зогсоох, хуульд заасан үндэслэл журмын дагуу хуулийн байгууллагад шилжүүлэн хариуцлага тооцуулах;

- Захиран тушаах уламжлалт арга барилаас илүүтэйгээр хүнлэг ёсыг бий болгон бүх шатны захирагч, дарга нарын манлайлал, үлгэр жишээч байдал, цэргийн дүрэмд заагдсан эелдэг зан, харилцаанд анхаарч, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх;

- Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагад ажиллах нөхцөл, хугацааг цэргийн алба хаагчдын амьдрах, алба хаах орчныг орчин үеийн жишигт ойртуулан сайжруулах, материал, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчлэх зэрэг болно.

---oOo---


**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ**

2021 оны 04 сарын 02 өдөр МОНГОЛ УЛСЫН МҮҮД Дугаар 1171

Улаанбаатар хот

**Зэвсэгт хүчний сахилга, хариуцлагыг сайжруулах
зохион байгуулалтын арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.11, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.12, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах, төрийн албан хаагчийн ёс зүйг өндөржүүлэхийн тулд Зэвсэгт хүчний офицерын бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар, ёс зүйн түвшинг тогтоох үзлэгийг 2021 онд зохион байгуулж, офицер нэг бүрийн албандаа хандах хандлагыг өөрчлөн сайжруулах, цэргийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т даалгасугай.


2. Батлан хамгаалахын сайдын дэргэд Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Иргэний зөвлөл"-ийн дүрэм, ажиллах журмын төслийг боловсруулж танилцуулахыг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч /хурандаа Ж.Болдбаатар/-д хариуцуулсугай.

3. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын биелэлтэд байнгын хяналт тавьж, 7 хоног бүр ахлах захирагч /дарга/-даа илтгэж байх журам тогтоож мөрдөхийг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын захирагч нарт үүрэг болгосугай.

4. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын цэргийн байр, танхим, бусад барилга байгууламжийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан камерын хяналттай болгох зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, хугацаат цэргийн алба хаагчидтай холбоотой асуудлаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах тусгай дугаарыг ажиллуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/-д хариуцуулсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100186



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

— 2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/80

— Улаанбаатар хот

Хөрөнгө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18¹.3.6 дахь заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын 2021 оны 2/814 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


камер

1. Зэвсэгт хүчний ангиудад шаардлагатай хяналтын камер болон дагалдах хэрэгслийн жагсаалтыг нэгдүгээр, Үндэсний батлан хамгаалахын их сургуульд шаардлагатай хяналтын камер дагалдах хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан хяналтын камер, дагалдах хэрэгслийг худалдан авахад шаардлагатай 116,979,600.00 (нэг зуун арван зургаан сая есөн зуун далан есөн мянга зургаан зуу) төгрөгийг Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хэмнэлтээс гаргаж, санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/, холбогдох эрх зүйн хүрээнд худалдан авах, холболт суурилуулалтын ажлыг шуурхай зохион байгуулж, дүнг илтгэхийг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, Үндэсний батлан хамгаалахын их сургууль /бригадын генерал П.Жаргалан/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.


САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100196

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
04 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар
тушаалын нэгдүгээр хэсгээр



**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУДАД ШААРДЛАГАТАЙ ХЯНАЛТЫН КАМЕР БОЛОН ДАГАЛДАХ
ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Эд хэрэгслийн жагсаалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	нийт үнэ /төгрөг/
1	Бичигч	КОМ	22	850,000.00	18,700,000.00
2	Гадна камер	КОМ	32	1,000,000.00	32,000,000.00
3	Дотор камер	КОМ	106	78,000.00	8,268,000.00
4	Салаалагч /switch24 port/	КОМ	30	95,000.00	2,850,000.00
5	RJ-45 толгой	Ш	1152	350.00	403,200.00
6	Телевизор 55 инч	Ш	22	750,000.00	16,500,000.00
7	Сүлжээний кабель	М	6130	850.00	5,210,500.00
8	HDMI кабель	Ш	22	8,500.00	187,000.00
9	Далдлагч	Ш	2344	5,600.00	13,126,400.00
	НИЙТ ДҮН				97,245,100.00

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
04. дугаар сарын 12-ны өдрийн 180 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД ШААРДЛАГАТАЙ
ХЯНАЛТЫН КАМЕР ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эд хэрэгслийн жагсаалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	нийт үнэ /төгрөг/
1	Камер (гадна)	ком	20	130,000.00	2,600,000.00
2	Камер (дотор)	ком	50	115,000.00	5,750,000.00
3	Камерны хөл	ш	15	7,000.00	105,000.00
4	NVR (64 оролттой)	ш	1	1,650,000.00	1,650,000.00
5	NVR (32 оролттой)	ш	1	380,000.00	380,000.00
6	NVR (16 оролттой)	ш	1	350,000.00	350,000.00
7	Свитч (16 порттой)	ш	2	350,000.00	700,000.00
8	Свитч (8 порттой)	ш	3	120,000.00	360,000.00
9	Свитч (5 порттой)	ш	1	75,000.00	75,000.00
10	Зурагт (65 инч)	ш	2	1,500,000.00	3,000,000.00
11	Адаптер (12В)	ш	60	7,000.00	420,000.00
12	Камерны хос кабель	боодол	3	220,000.00	660,000.00
13	STP кабель	хайрцаг	1	280,000.00	280,000.00
14	Сүлжээний толгой	хайрцаг	5	40,000.00	200,000.00
15	DC толгой	ш	75	1,100.00	82,500.00
16	Hard disc	ш	2	360,000.00	720,000.00
17	Уртасгагч (APS)	ш	4	45,000.00	180,000.00
18	РАК	ш	2	150,000.00	300,000.00
19	РАК (жижиг)	ш	3	50,000.00	150,000.00
20	Медиа конвертер	хос	4	293,000.00	1,172,000.00
21	Шилэн кабель	м	600	1,000.00	600,000.00
	НИЙТ ДҮН				19,734,500.00

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ



**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД**

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 51, Засгийн газрын VII байр,
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
И-мэйл: info@mod.gov.mn, Вэбсайт: www.mod.gov.mn

2021. 04. 13 № 1^а/1250
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын батлан хамгаалах бодлого, төрийн цэргийн байгууллагын тогтолцоо, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн хамгааллыг сайжруулах эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа Танд талархлаа илэрхийлбэ.


Сүүлийн жилүүдэд цэргийн нэгтгэл, ангийн байрлалд, цэргийн алба хаагчдын дунд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил болон хууль, дүрмийн бус харьцаа, үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрсдэх, эрүүл мэндээр хохирох асуудал буурахгүй байгаа бөгөөд үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь архидалт, согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой болох нь шат шатны байгууллагын хяналт, шалгалтын үнэлгээ, дүгнэлтээс харагдаж байгаа юм.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн цэргийн алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байхдаа архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай" /шинэчилсэн найруулга/-ын хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаатай холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

Асуудлыг судлан үзэж, хуулийн төсөлд тусгаж өгөхийг хүсье.

Хувийг: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр;
Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга Б.Энхбаяр;
Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нарт.

Хүндэтгэсэн,



САЙХАНБАЯР

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Нэг. Хууль зүйн байнгын хороонд зарчмын зөрүүтэй санал гаргах:

1. Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт дараах заалтыг нэмэх:

30.1.4. "Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.2, 4.3, 4.4-т заасны дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч" гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ГАРАХ
ХУУЛИЙН-ТӨСӨЛД ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ НЭМЖ ОРУУЛАХ САНАЛ:**

Нэг. Хууль зүйн байнгын хороонд гаргах зарчмын санал:

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төсөлд Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэмж оруулах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн албаны тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг:

"24.3.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 30.1.4-т заасныг зөрчсөн цэргийн алба хаагчийг төрийн албанд хоёр жилийн хугацаанд эргэж орох нөхцөлгүйгээр халах."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалахын сайдад дэмжлэг үзүүлэх, цэрэг-иргэний харилцааг бэхжүүлэхэд оршино.

1.3. Зөвлөл үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга, ил тод, нээлттэй, хараат бус байх зарчмыг баримтална.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомж, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, энэ журмыг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн даргыг анхны хуралдаанаар зөвлөлийн бүрэлдэхүүнээс нэр дэвшүүлэн олонхын саналаар сонгоно.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл шаардлагатай тохиолдолд төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, ангид ажиллаж болно.

2.4. Ээлжит болон ээлжит бус хуралдаан, цэргийн нэгтгэл, ангид ажиллах ажлын тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг нарийн бичгийн дарга хуралдаан эхлэхээс 7 хоногийн өмнө гаргаж, гишүүдэд мэдэгдэнэ.

2.5. Зөвлөл нь Батлан хамгаалахын сайдын бүрэн эрхийн хугацаанд ажиллах бөгөөд түүнд үйл ажиллагаагаа тайлагнана.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг

3.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. зэвсэгт хүчин дэх хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, түүнийг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гаргах;

3.1.2. зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах санал, зөвлөмж гаргах;

3.1.3. хүний эрхийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн талаар санал, зөвлөмж гаргах;

3.1.4. зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, мэдээлэл боловсруулан Батлан хамгаалахын сайдад уламжлах;

3.1.5. батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хүүхэд, залуучуудыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, явуулах;

3.1.6. хугацаат цэргийн алба хаагчдын ар гэр, гэр бүлтэй цэргийн нэгтгэл, ангийн удирдлагыг холбох, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

3.1.7. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх зөвлөлтэй хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Батлан хамгаалах яамны хүлээх үүрэг

4.1. Батлан хамгаалах яам нь Зөвлөлтэй хамтран ажиллах талаар дараах үүргийг хүлээнэ:

4.1.1. зөвлөлийг албаны өрөө, шаардлагатай техник хэрэгслээр хангах, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг санхүүжүүлэх

4.1.2. хууль, тогтоомжийн хүрээнд Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

4.1.3. зөвлөлийн хуралдаанаас гарсан зөвлөмж, санал, дүгнэлтийн хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд шалтгаан, үндэслэлийг зөвлөмжид заасан хугацаанд нь эргэж мэдэгдэх;

4.1.4. Зөвлөлийн даргын хүсэлтээр яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, ангийн холбогдох албан тушаалтныг Зөвлөлийн хуралдаанд оролцуулах.

4.2. Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албанаас нэг ажилтныг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилон ажиллуулна.

Тав. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

5.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Батлан хамгаалахын сайдын төсвийн багцаас санхүүжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Архидан согтуурахтай тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 27.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж байгууллагад архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай. Үүнд:

1.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, энэ талаар гарсан хууль, тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, архины улмаас нийгэмд учирч буй хор уршгийг нийт цэргийн алба хаагч, ажилтнуудад сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулах;

1.2. Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоож, ажлын байранд согтууруулах ундааг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэхийг хориглосон заалтыг дотоод журамдаа тусгах, түүнийг зөрчсөн цэргийн алба хаагчийн цэргийн цол, албан тушаалыг бууруулах, албан тушаалаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлэх;

1.3. Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын байр, албаны өрөө, тасалгаа, хичээлийн танхимд байнга үзлэг явуулж хэвшүүлэх;

1.4. Архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд офицер, ахлагч, ажилтан, албан хаагч бүртэй "Ёс зүйн гэрээ" байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;

1.5. Цэргийн алба хаагч, ажилтны согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, дүн шинжилгээ хийж, дахин гаргахгүй байх бүхий л талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1321100212

усад төрлийн 1.6. Байгууллага, хамт олны баяр, ёслолын болон бусад төрлийн бүх арга хэмжээг зохион байгуулахдаа архи, согтууруулах ундааг хориглож, хэрэглэхгүй болгож хэвшүүлэх;


1.7. Цэргийн нэгтгэл, анги байгууллага бүр байрлаж байгаа нутаг дэвсгэрийн Засаг даргын Тамгын газар болон бүх шатны хууль, хяналтын байгууллагатай архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бүх талаар хамтран ажиллах.

2. Цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг холбогдох хуульд тусгах санал боловсруулж, танилцуулахыг яамны Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг улирал тутам Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэдэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөл /Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай/-д хариуцуулсугай.

САЙД  Г.САЙХАНБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМЖИРШЛААНЫ
ХОШУУЧ ГЕНЕРАЛ ДАРГА
Д.ГАНЗОРИГ



2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДРИЙН
02 ДУГААР ТОГТООЛЫН ДАГУУ ЗЭВСЭГТ ХҮЧИНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Зэвсэгт хүчний офицер, ахлагч, байлдагч, түрүүч нарын сахилга, хариуцлагыг чангатгах, цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэлийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн зохион байгуулах, Зэвсэгт хүчинд гарсан гэмт хэрэг, осол, дүрмийн бус харьцааны зөрчлийн шатгаан нөхцөлийг 2021 оны 04 дүгээр сарын 08-наас 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд тодорхойлох арга хэмжээг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Д/д	Зохион байгуулах ажил, арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хугацаа
1	2	3	4	5
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:				
1	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоол, хуралдааны шийдвэрт тусгагдсан асуудалд дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох	Хүний эрхийн дэд хорооны хуралдааны шийдвэр, тогтоолын дагуу Зэвсэгт хүчний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулж баталгаажуулна.	ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга	2021.04.08

ХАМГААГАХ ТӨЛӨӨ

1	2	3	4	5
2	Захирагч, даргын гаргах тушаал, шийдвэр хүний эрхийн үндсэн зарчим, агуулга, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх Ажлын хэсэг байгуулж, ажиллуулах	ЗХЖШ-ын дарга, Төрлийн цэргийн командлагч, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын дарга нарын тушаал, шийдвэр хүний эрхийн зарчим, агуулга, хэм хэмжээнд нийцсэн эсэхэд шинжилгээ үнэлгээ чиглэл бүхий Ажлын хэсгийг байгуулна.	Ажлын хэсэг	2021.04.08- 2021.06.05
3	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны гишүүдэд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг танилцуулах	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны гишүүдэд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын үйл ажиллагаа, хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт бэлтгэл, ахуй хангалт, нөхцөл байдалтай танилцуулна.	АУГ	2021.04
4	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны хуралдааны шийдвэр, тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлагнах	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанааны шийдвэр, тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг УИХ-ын Хүний эрхийн дэд хороонд танилцуулах мэдээгээр танилцуулна.	ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга	Долбоо хоног бүр
5	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Хүний эрхийн үндэсний комисст авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн талаар танилцуулж, мэдээлэх	УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны 2021 оны 02 дугаар тогтоолын мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Хүний эрхийн үндэсний комисст тайлагнаж, мэдээлнэ.	ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга	Долбоо хоног бүр
6	Зэвсэгт хүчний үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актуудад шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулах	Зэвсэгт хүчний Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, түүнийг дагалдан гарсан эрх зүйн баримт бичгүүдэд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, хязгаарласан зохицуулалт	Ажлын хэсэг	2021.04.08- 2021.06.05

1	2	3	4	5
		байгаа эсэхэд шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн төсөл боловсруулж, Хүний эрхийн дэд хороонд танилцуулах		
Хоёр. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:				
7	Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад сахилга, хариуцлагыг чангатгах, сайжруулах чиглэлээр үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах	Шат шатны хариуцлагыг чангатгах, сайжруулах чиглэлийн хүрээнд сахилга, хариуцлагыг сайжруулах үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулахад хяналт тавьж ажиллана.	ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар	2021.04.08-2021.06.05
8	Цэргийн алба хаагчын албандаа хандах шинэ хандлага, эрх зүйн ухамсарыг дээшлүүлэх зорилгоор "Цэргийн алба хаагчийн нийгмийн хариуцлага" сэдэвт сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжүүлэх	Цэргийн алба хаагчын албандаа хандах шинэ хандлага, эрх зүйн ухамсарыг дээшлүүлэх зорилгоор "Цэргийн алба хаагчийн хөгжил-нийгмийн хариуцлага" сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг зохион байгуулна.	Сургалтын хэлтэс, ЦАХэлтэс	2021.04.08-2021.06.05
9	Цэргийн сургалт, бэлтгэлийн хөтөлбөрт тусгагдсан хүний эрхийн сургалтыг агуулгыг боловсронгуй болгож, мөрдүүлэх	Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөрт тусгагдсан хүний эрхийн сургалтын агуулга, арга барил, хэлбэрийг ХЭҮК-той хамтран боловсронгуй болгож, сургалтыг зохион байгуулна.	Сургалтын хэлтэс	2021.04.08-2021.06.05
10	ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, цаг үеийн холбогдолтой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх	Цаг үеийн болон төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгнө.	Салбар зөвлөл	2021.04.08-2021.06.05
11	Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Архидан согтуурах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" уриалга, өгсөн үүрэг даалгавар, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Монгол Улсын Засгийн газрын Төрийн албаны сахилга	Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн тохиолдолд бүрийг таслан зогсоож, нийт бие бүрэлдэхүүнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглосон тушаал, шийдвэрийг гаргаж, биелэлтийг хангуулахад хяналт тавина.	ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж	2021.04.08-2021.06.05

1	2	3	4	5
1	хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны 336 дугаар тушаал, ЗХЖШ-ын даргын 2017 оны 535 дугаар тушаалын заалтуудын биелэлтийг хангуулах, хяналт тавих			
12	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтнуудад сурган зааварлах хичээл явуулах	Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийн хүрээнд бүх шатны жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг албан тушаалтнуудад сурган зааварлах хичээл, сургалтыг зохион байгуулна.	АУГ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги	2021.04.08-2021.06.05
13	Цэргийн цагдаагийн үйл ажиллагаа, ач холбогдлын талаар УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Цагдаагийн ерөнхий газарт танилцуулж, хамтран ажиллах	Цэргийн албаны болон дүрмийн бус харьцааны зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэл бүхий цэргийн цагдааг байгуулж, үйл ажиллагааг хэвшүүлэхийн ач холбогдол, давуу талын талаар Хүний эрхийн дэд хорооны гишүүдэд танилцуулж, УПЕГ, ХЭҮК, ЦЕГ-тай хамтран ажиллах	ЦАХэлтэс	2021.05.25-ны өдрийн дотор
14	Цэргийн алба хаагчдын гаргасан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийн талаар мэдээлэл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх зорилго бүхий цагдаагийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох	Цэргийн алба хаагчдын гаргасан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийн талаар мэдээлэл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх зорилго бүхий цэргийн цагдаагийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжүүлнэ.	БСТГ, ЦАХэлтэс	2021.04.15
15	2010-2021 оны хооронд цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн судалгааг авч, дүн шинжилгээ хийх	Гурав. Мэдээлэл, дүн шинжилгээний чиглэлээр: 2010-2021 оны хооронд гэмт хэрэг үйлдсэн цэргийн алба хаагчдад прокурор, шүүхээс оногдуулсан ял шийтгэл /хэрэгсэхгүй болгосон, шүүхээс ял шийтгүүлсэн/-ийн	ЗУХ, ЦАХэлтэс	2021.05.08-ны дотор

1	2	3	4	5
		судалгааг авч, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийнэ.		
16	2010-2021 оны хооронд нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан офицер, ахлагч, байлдагч, түрүүч нарын статистик судалгааг авч, дүн шинжилгээ хийх	2010-2021 оны хооронд нас барсан болон хөдөлмөрийн чадвараа алдсан офицер, ахлагч, байлдагч, түрүүч нарын тоон үзүүлэлт бүхий статистик судалгааг авч, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийнэ.	ХШҮГ, ЦАХэлтэс, Төрлийн цэргийн командлал	2021.05.08-ны өдрийн дотор
17	2010-2021 оны хооронд сахилга, хариуцлагаар халагдсан цэргийн алба хаагчдын судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийх	2010-2021 оны хооронд сахилга, хариуцлага /архи уусан, гэмт хэрэг үйлдсэн, дүрмийн зөрчил гаргасан гэх мэт/-аар цэргийн жинхэнэ албанаас халагдсан алба хаагчдын судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийнэ.	ХНХ	2021.05.08-ны өдрийн дотор
18	2010-2021 оны хооронд цэргийн алба хаагчдад олгосон тэтгэмж, тусламжийн судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийх	2010-2021 оны хооронд нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан офицер, ахлагч, байлдагч, түрүүч болон тэдний ар гэрт олгосон нэг удаагийн тэтгэмж, зөвсөгт хүчний нэгтгэл, анги, байгууллагаас олгосон тусламж дэмжлэгийн дэлгэрэнгүй судалгаа гаргаж, дүн шинжилгээ хийнэ.	Санхүүгийн хэлтэс	2021.05.08-ны өдрийн дотор
19	2010-2021 оны Зөвсөгт хүчний төсөв, санхүүжилтийн мэдээ, бүртгэлийн үзүүлэлтийг гаргах	2010-2021 онд Зөвсөгт хүчний үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлсэн байдал, төсвийн өсөлт, бууралт үзүүлэлтийг гаргаж, дүн шинжилгээ хийнэ.	Санхүүгийн хэлтэс	2021.06.01-ний өдрийн дотор
20	2010-2021 оны хооронд цэргийн дүрмийн бус харьцааны зөрчил болон албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан байдалд дүн шинжилгээ хийж, буруутай албан тушаалтнуудад оногдуулсан хариуцлагын талаарх судалгааг гаргах	Цэргийн дүрмийн харьцааны зөрчил гаргаж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэний улмаас офицер, ахлагч, байлдагч, түрүүч нас барсан, хөдөлмөрий чадвараа алдсан тохиолдолд дүн шинжилгээ хийж, буруутай албан тушаалтнуудад оногдуулсан хариуцлагын талаарх судалгааг сүүлийн 10 жилийн байдлаар гаргаж, нэгтгэнэ.	ХНХ, ХШҮГ	2021.05.25-ны өдрийн дотор

1	2	3	4	5
21	Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын сайшаал, шийтгэлийн мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийх	Зэвсэгт хүчний офицер, ахлагч, байлдагч, түрүүч нарын сайшаал, шийтгэлийн мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийнэ.	ЦАХэлтэс, ХНХ	2021.05.25-ны өдрийн дотор
		Дөрөв. Мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлын чиглэлээр:		
22	Монгол Улсын хууль тогтоомж, "Цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн албыг зохион байгуулах заавар", дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх талаар гарсан тушаал, шийдвэрийг Зэвсэгт хүчний анги, байгууллагын бие бүрэлдэхүүнд судлуулах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	Цэргийн сэтгэл зүйч, хуулийн-офицеруудын хүч оролцоонд тулгуурласан урьдчилан сэргийлэх сургалтыг цахим, танхимын хосолсон хэлбэрээр цар тахлын хорио дэглэм, хязгаарлалт, зөвлөмжийн дагуу зохион байгуулна.	АУГ, ЗУХ	2021.04.15-наас 11 11
23	Монгол Улсын хүний эрхийн үндэсний комисстой хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн дагуу ХЭҮК-той хамтран ажиллаж, хүний эрхийн сургалт зохион байгуулах	ХЭҮК-той хамтран цахим болон танхимын хосолсон байдлаар хүний эрхийн сургалтыг зохион байгуулж явуулна.	АУГ, ЗУХ	Тухай бүр
24	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгэл зүй, хууль, эрх зүйн танхим байгуулж, ажиллуулах	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн алба хаагч, ажилтан албан хаагчдад эрх зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмжөөр хангах чиглэлээр Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын сэтгэл зүйн танхимыг түшиглэн "Сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх танхим" төхөөрөмжлөх, ажиллуулна.	ЗУХ, МТГ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага	2021.05.10-ны өдрийн дотор
25	Гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан нөхцөл, үр дагаврын талаар сургамжит хэлэлцүүлэг зохион байгуулах	Цэргийн албаны болон дүрмийн харьцааны зөрчил, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулж, үнэлт дүгнэлт өгч, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.	Салбар зөвлөл, Зохин байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлал	2021.04.08-05.28
26	Цэргийн алба сахилга, зохион байгуулалтын чиглэлээр нийт бие бүрэлдэхүүнээс	Цэргийн албанд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил, дүрмийн бус харьцааны зөрчлийн	АУГ, Төрлийн цэргийн	2021.04.08-05.28

1	2	3	4	5
	социологийн судалгаа авч, үнэлэлт дүгнэлт өгөх	шалтгаан нөхцөл, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахууны төлөвшлийн талаар социологийн судалгаа авч, дүгнэлтэд тулгуурласан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	командлал	5
27	Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлах, иргэний хяналтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, зохион байгуулах	Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй танилцуулах, сурталчлах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хугацаат цэргийн алба хаагчдын ар гэр, хэвлэлийн төлөөлөлттэй хамтран "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	АУГ, МАБА, ЦГХАХ, Төрлийн цэргийн командлал	2021.05.25-ны өдрийн дотор
28	Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ард иргэдэд сурталчлах	Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран сурталчилгааны ажлыг хэрэгжүүлнэ.	АУГ, МАБА, ХМА	2021.04.08-06.08
29	Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан хугацаат цэргийн алба хаагчдад "Илгээмжийн үйлчилгээ"-гээр дамжуулан ар гэрээс нь шаардлагатай ахуйн хангалт, бусад хэрэгслийг дамжуулан авч, олгох зохицуулалтыг боловсронгуй болгож, нэвтрүүлэх	Цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан хугацаат цэргийн алба хаагчдад "Илгээмжийн үйлчилгээ"-гээр дамжуулан ар гэрээс нь шаардлагатай ахуйн хангалт, бусад хэрэгслийг дамжуулан авч, олгох зохицуулалтыг боловсронгуй болгож, нэвтрүүлнэ.	МТГ, АУГ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги	2021.04.08-06.08
30	Зэвсэгт хүчний анги, байгууллагуудад цэргийн албаны хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж явуулахад дэмжлэг үзүүлэх, ЗХЖШ-аас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар бие бүрэлдэхүүнд сурталчлах	Зэвсэгт хүчний анги, байгууллагуудад цэргийн албаны хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж явуулахад дэмжлэг үзүүлэх, ЗХЖШ-аас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар бие бүрэлдэхүүнд	ХШУГ, Төрлийн цэргийн командлал	2021.04.08-06.08

Тав. Хяналт, шалгалтын чиглэлээр:

1	2	3	4	5
		танилцуулж, мэдээлнэ.		
31	Зэвсэгт хүчний анги, байгууллагад “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хэрэгжилт, сахилга дэг журам, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтийн байдлыг шалган туслах, үнэлэлт, дүгнэлт өгөх	Зэвсэгт хүчний анги, байгууллагад “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн хэрэгжилт, сахилга дэг журам, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтийн байдлыг шалган туслах, үнэлэлт, дүгнэлт өгч, зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ХШҮГ, Төрлийн цэргийн командлал	2021.04.08-06.08
32	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын цэргийн албаны зохион байгуулалт, сахилга дэг журмын байдалд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх	ЗХЖШ-ын даргын баталсан удирдамжийн дагуу цэргийн албаны зохион байгуулалт, сахилга, дэг журмын байдалд албаны шалтгалт явуулж, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	ХШҮГ	2021.04.08-06.08
33	Гэмт хэрэг, архидаг согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тусгай судалгаа гаргаж, дүгнэлт хийх	Гэмт хэрэг, архидаг согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тусгай судалгаа гаргаж, дүгнэлт хийнэ.	ХШҮГ, ЦАХэлтэс	2021.04.08-06.08
34	Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийн гомдол, мэдээллийн дагуу албаны шалгалтыг явуулж, үнэлэлт дүгнэлт өгөх	Цэргийн алба хаагч, иргэдээс ирсэн гомдол, мэдээллийн мөрөөр албаны шалгалт явуулж, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Томилогдсон комисс	Тухай бүр

ХЯНАСАН:

ЗХЖШ-ЫН НЭГДҮГЭЭР ОРДӨГЧ ДАРГА

ХУРАНДАА *[Signature]* Ц.ЖАВХЛАНБААТАР

ТӨЛӨВЛӨСӨН:

ЗХЖШ-ЫН ЗАХИРГААНЫ УДИРДААГЫН ХЭЛТСИЙН

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ АХЛАХ МӨРГЭЖИЛТЭН

АХМАД *[Signature]* А.ЭРДЭНЭМӨНХ



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 1481

Улаанбаатар хот

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сэтгэл зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнд эрх зүйн мэдлэг, боловсрол олгох, хуулийг сурталчлан таниулах, ойлголт өгөх, алба хаагчийн сэтгэл зүйн байдалд судалгаа хийж, цэргийн албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 12-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж явуулсугай.

2. Тушаалын 1 дэх заалтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах материал хэрэгслийн зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 2,021,000.00 (хоёр сая хорин нэгэн мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үйлчлэх автомашиныг зохих лимиттэйгээр гаргах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн судалгаа явуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бие бүрэлдэхүүний бэлтгэл ажлыг сайтар ханган, ажлын удирдамжийг баталгаажуулж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, ажлын үр дүнг нэгтгэж Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /хурандаа Ж.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.



Г.САЙХАНБАЯР

1321100206

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
06 дугаар сарын 12-ны өдрийн 11/ дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, СЭТГЭЛ ЗҮЙН
БҮРЭГ СУДАЛГАА ЯВУУЛАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:
Ж.Болдбаатар

Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч,
хурандаа;

Орлогч дарга:
С.Дашзэвэг

Зэвсэгт хүчний Жанжин штабын
Ажиллагааны удирдлагын газрын дарга,
бригадын генерал;

Ажлын хэсгийн гишүүд:
Г.Энхболд

яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн
газрын Хуулийн хэлтсийн дарга, хуулийн
зөвлөх;

Н.Төрмөнх

Батлан хамгаалах яамны Стратегийн
бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч;

А.Эрдэнэмөнх

Зэвсэгт хүчний Жанжин штабын Захиргааны
удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөх-ахлах
мэргэжилтэн, ахмад;

Д.Отгонгэрэл

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн
командлалын Захиргааны удирдлагын
хэлтсийн хуулийн офицер, дэслэгч;

Э.Энхээ

Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн хуулийн
офицер, дэслэгч;

Г.Алдрай

Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн хуулийн
офицер, дэслэгч;

Г.Пүрэвсүрэн

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн
хуулийн зөвлөх;

Г.Мягмаржав

Монгол Улсын гавьяат багш, чөлөөнд байгаа
хурандаа;

С.Энхтайван

Бэлтгэл хурандаа;

Г.Амгалан

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн
Цэргийн нэгдсэн сургуулийн сэтгэл зүйн
багш, ахлах дэслэгч;

С.Даваасамбуу

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн
Тэмүүжин өрлөг сургуулийн сэтгэл зүйч-
багш;

Г.Солонго


Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн
Тэмүүжин өрлөг сургуулийн нийгмийн
ажилтан.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Н.Пүрэвдорж

яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын Зэвсэгт хүчний бэлэн
байдал, зэвсэглэл, цэргийн техникийн
ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үнэлгээ
хариуцсан ахлах мэргэжилтэн, хурандаа.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ



Батлангхамгаалахын сайдын 2021 оны 04 дүгээр сарын 21 ны өдрийн 18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, СУРГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд цэргийн алба болон нийгмийн харилцааны асуудалд эрх зүйн соёл, ухамсартайгаар хандаж, хуулийг зөв хэрэглэх хандлагыг төлөвшүүлэх, эрх зүйн мэдлэг боловсрол олгох, хуулийг сурталчлан таниулах, ойлголт өгөх, алба хаагчийн сэтгэл зүйн байдалд судалгаа хийж, цэргийн албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга зам	Хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан	Хугацаа	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6
1	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад зохион байгуулах "Хууль хэрэглэх зөв хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулах, сэтгэл зүйн судалгаа, сургалт явуулах тушаал, шийдвэрийг баталгаажуулах	Батлангхамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнд эрх зүйн мэдлэг, боловсрол олгох, хуулийг сурталчлан таниулах, ойлголт өгөх, алба хаагчийн сэтгэл зүйн байдалд судалгаа хийж, цэргийн албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох шийдвэрийг гаргаж, баталгаажуулна.	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурандаа Н.Пүрэвдорж	2021.04.12	Сургалт зохион байгуулах, судалгаа явуулах эрх зүйн үндэс бүрдэнэ.
2	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын бие бүрэлдэхүүнд гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг олгох зорилго бүхий	Гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийг зөв хэрэглэх хандлага, соёл, ухамсар төлөвшүүлэх зорилго бүхий хууль сурталчлах сургалтын хөтөлбөр,	Хуулийн бүлэг Г.Энхболд	2021.04.15	Сургалт явуулах бүлгийн цэргийн нэгтгэл, анги, салбарт ажиллах хуваарь, маршрут

	“Хууль хэрэглэх зөв хандлага” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, ажлын удирдамж батлуулах	төлөвлөгөө, хуваарийг тодорхойлж, боловсруулна.			тодорхой болж, сургалтын зохион байгуулалт хангагдана.
3	ЭХЖШ, төрлийн цэргийн командлалууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын сэтгэл зүйн хангалт хариуцсан албан тушаалтнуудтай цахим сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	Сэтгэл зүйн хангалт хариуцсан албан тушаалтнуудтай цахим сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулна.	БХЯ, ЭХЖШ	2021.04.16	Сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдана.
4	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудад алба хааж буй бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тандалт, судалгаа авах, цэрэг дайчдын сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг илрүүлэн судлах, сэтгэл зүйн тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх судалгаа, сургалтын хөтөлбөр, удирдамжийг боловсруулж, батлуулах	Сэтгэл зүйн байдлыг тогтоох, судалгаа, сургалтын ажлын агуулга, бүлгийн бүрэлдэхүүнийг дадлагажуулах арга хэмжээг зохион байгуулна.	Сэтгэл зүйчдийн бүлэг Г.Мягмаржав Л.	2021.04.20	Судалгаа, сургалт явуулах бүлгийн цэргийн нэгтгэл, анги, салбарт ажиллах хуваарь, Маршрут тодорхой болж, сургалтын зохион байгуулалт хангагдана.
5	Хууль сурталчлах сургалтын хөтөлбөр, удирдамжийн хүрээнд сургалтын агуулга, сэдвийн хамрах хүрээг тодорхойлж, хуулийн бүлгийн бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулах	Сургалтын агуулга, хамрах хүрээ, сэдвийг бэлтгэж, сургалтыг зохион байгуулах бүлгийн бүрэлдэхүүнийг дадлагажуулах арга хэмжээг зохион байгуулна.	Хуулийн бүлэг Г.Энхболд	2021.04.15 -04.30	Сургалт зохион байгуулах бүрэлдэхүүн дадлагажина

6	Судалгаа, сургалтын хөтөлбөр, удирдамжийн хүрээнд цэргийн алба хаагчдаас авах судалгааны маягт, загвар, унших лекц зэргийг бэлтгэж, сэтгэл зүйн бүлгийн бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулах	Судалгааны маягт, загвар, асуулга, ярианы сэдвийг тодорхойлж, судалгаа, сургалтыг зохион байгуулах бүлгийн бүрэлдэхүүнийг дадлагажуулах арга хэмжээг зохион байгуулна.	Сэтгэл зүйчдийн бүлэг Г.Мягмаржав	2021.04.15 -04.30	Сургалт зохион байгуулах бүрэлдэхүүн дадлагажина
7	Сургалтад шаардлагатай мэдээлэл, сурталчилгааны болон техникийн бэлтгэл ажлыг хангах	Сургалтыг зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгааны видео хичээл, хулдаасан хэвлэл, техникийн бэлтгэлийг хангана.	ЭХЖШ-ын Захиргааны удирдлагын хэлтэс	2021.04.25	Сургалт зохион байгуулах бэлтгэл хангагдана
8	Батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу сургалт зохион байгуулах бүлгүүд цэргийн нэгтгэл, анги, салбарт ажиллах	Томилогдсон бүлэг батлагдсан маршрут, хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулна.	Сургалт зохион байгуулах бүлгүүд Г.Энхболд Г.Мягмаржав	2021.05.01 -12.15	Цэргийн алба хаагчдын эрх зүйн мэдлэг тодорхой түвшинд дээшилж, бие бүрэлдэхүүнд сэтгэл зүйн тандалт, судалгаа явагдана.
9	Хууль сурталчлах сургалтыг төв, орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагаар сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлэх	Хууль сурталчлах сургалтыг хэвлэл мэдээллийн хамтран сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Соёмбо редакц Дуулга студи	2021.05.01 -12.31	Ажлын явц, үр дүн олон нийтэд хүрсэн байна.
10	"Хууль хэрэглэх зөв хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулах, сэтгэл зүйн судалгаа, сургалт явуулах бүлгүүдийн ажлын үр дүнг нэгтгэж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах	Үр дүн нэгтгэгдэж, тайлан гаргаж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах материал бэлтгэнэ.	Ажлын хэсгийн дарга хурандаа Ж.Болдбаатар Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хурандаа Н.Пүрэвдорж	2021 оны 12 дугаар сард	Ажлын хэсгийн ажлын үр дүн гарсан байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тушаалын гуравдугаар хэвсрэлт



АЖЛЫН ХЭСГИЙН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖИЛД
ШААРДАГДАХ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ТӨӨЦӨМ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Хэмжээ	Хэрэгцээ	Бүгд үнэ /төгрөг/
1	Хулдаас /анонс/	м ²	8000	36 м ²	2	576,000
2	CD	ш	800	-	300	240,000
3	USB заагуур	ш	80000	-	2	160,000
4	Бичгийн цаас	боодол	13000	-	25	325,000
5	Принтерийн хор	ш	60000	-	12	720,000
	Нийт дүн					2,021,000

ХЯНАСАН:
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА ХУРАНДАА Д.ГАНБАТ

ТӨЛӨВЛӨСӨН:
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХУРАНДАА Н.ПҮРЭВДОРЖ

**“ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ЗӨВ ХАНДЛАГА” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, анги, байгууллагын хуваарь:

Д/д	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар	Хугацаа
Нэгдүгээр бүлэг		
1	Зэвсэгт хүчний 326 дугаар анги	2021.05.03
2	Зэвсэгт хүчний 120 дугаар анги	2021.05.04
3	Зэвсэгт хүчний 119 дүгээр анги	2021.05.05
4	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл	2021.05.06
5	Зэвсэгт хүчний 314 дүгээр анги	2021.05.07
Хоёрдугаар бүлэг		
1	Зэвсэгт хүчний 032 дугаар анги	2021.05.03
2	Зэвсэгт хүчний 015 дугаар анги	2021.05.04
3	Зэвсэгт хүчний 013 дугаар анги	2021.05.05
4	Зэвсэгт хүчний 014 дүгээр анги	2021.05.06
5	Зэвсэгт хүчний 017 дугаар анги	2021.05.07
Нэгдүгээр бүлэг		
1	Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	2021.05.10
2	Зэвсэгт хүчний 084 дүгээр анги	2021.05.11
3	Зэвсэгт хүчний 089 дүгээр анги	2021.05.12
4	Зэвсэгт хүчний 189 дүгээр анги	2021.05.13
5	Зэвсэгт хүчний 284 дүгээр анги	2021.05.14
Хоёрдугаар бүлэг		
1	Зэвсэгт хүчний 303 дугаар анги	2021.05.10
2	Зэвсэгт хүчний 011 дүгээр анги	2021.05.11
3	Зэвсэгт хүчний 142 дугаар анги	2021.05.12
4	Зэвсэгт хүчний 150 дугаар анги	2021.05.13
5	Зэвсэгт хүчний 311 дүгээр анги	2021.05.14
Нэгдүгээр бүлэг		
1	Зэвсэгт хүчний 350 дугаар анги	2021.05.17
2	Зэвсэгт хүчний 337 дугаар анги	2021.05.18
3	Зэвсэгт хүчний 015 дугаар анги	2021.05.19
Хоёрдугаар бүлэг		
1	Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэл	2021.05.17
2	Зэвсэгт хүчний 310 дугаар анги	2021.05.18
3	Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори	2021.05.19

Орон нутаг дахь зэвсэгт хүчний анги, салбарын хуваарь:

Д/д	Зэвсэгт хүчний анги, салбар	Засаг захиргааны нэгж
Нэгдүгээр бүлэг		
1	Зэвсэгт хүчний 232 дугаар анги	Хэнтий аймаг /Дэлгэрхаан/
2	Зэвсэгт хүчний 327 дугаар анги	Дорнод аймаг /Чойбалсан/
3	Зэвсэгт хүчний 085 дугаар салбар	Дорнод аймаг /Чойбалсан/
4	Зэвсэгт хүчний 329 дүгээр салбар	Дорнод аймаг /Халх гол/
5	Зэвсэгт хүчний 338 дугаар анги	Сүхбаатар аймаг /Баруун-Урт/

6	Зэвсэгт хүчний 168 дугаар салбар	Сүхбаатар аймаг /Баруун-Урт/
7	Зэвсэгт хүчний 086 дугаар салбар	Сүхбаатар аймаг /Баяндэлгэр/
8	Зэвсэгт хүчний 336 дугаар анги	Дорноговь аймаг /Зүүнбаян/
9	Зэвсэгт хүчний 253 дугаар салбар	Дорноговь аймаг /Улаанбадрах/
10	Зэвсэгт хүчний 281 дүгээр салбар	Дорноговь аймаг /Даланжаргалан/
11	Зэвсэгт хүчний 090 дүгээр салбар	Дорноговь аймаг /Хатанбулаг/
12	Зэвсэгт хүчний 167 дугаар анги	Өмнөговь аймаг /Даланзадгад/
13	Зэвсэгт хүчний 148 дугаар салбар	Өмнөговь аймаг /Даланзадгад/
14	Зэвсэгт хүчний 252 дугаар салбар	Өмнөговь аймаг /Хүрмэн/
15	Зэвсэгт хүчний 104 дүгээр салбар	Өмнөговь аймаг /Номгон/
16	Зэвсэгт хүчний 278 дугаар салбар	Дундговь аймаг /Мандалговь/
		36 хоног
Хоёрдугаар бүлэг		
1	Зэвсэгт хүчний 256 дугаар анги	Өвөрхангай аймаг /Арвайхээр/
2	Зэвсэгт хүчний 113 дугаар салбар	Өвөрхангай аймаг /Арвайхээр/
3	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	Баянхонгор аймаг /Баянхонгор/
4	Зэвсэгт хүчний 113 дугаар салбар	Баянхонгор аймаг /Баянхонгор/
5	Зэвсэгт хүчний 168 дугаар салбар	Баянхонгор аймаг /Баянговь/
6	Зэвсэгт хүчний 304 дүгээр салбар	Говь-Алтай аймаг /Алтай/
7	Зэвсэгт хүчний 332 дугаар салбар	Ховд аймаг /Зэрэг/
8	Зэвсэгт хүчний 123 дугаар анги	Ховд аймаг /Ховд/
9	Зэвсэгт хүчний 305 дугаар салбар	Ховд аймаг /Булган/
10	Зэвсэгт хүчний 340 дүгээр анги	Баян-Өлгий аймаг /Сагсай/
11	Зэвсэгт хүчний 116 дугаар салбар	Баян-Өлгий аймаг /Улаанхус/
12	Зэвсэгт хүчний 331 дүгээр анги	Баян-Өлгий аймаг /Өлгий/
13	Зэвсэгт хүчний 328 дугаар салбар	Увс аймаг /Зүүнговь/
14	Зэвсэгт хүчний 247 дугаар салбар	Завхан аймаг /Сонгино/
15	Зэвсэгт хүчний 325 дугаар анги	Завхан аймаг /Улиастай/
16	Зэвсэгт хүчний 321 дүгээр салбар	Хөвсгөл аймаг /Мөрөн/
17	Зэвсэгт хүчний 234 дүгээр анги	Булган аймаг /Хялгант/
18	Зэвсэгт хүчний 186 дугаар анги	Орхон аймаг /Эрдэнэт/
19	Зэвсэгт хүчний 110 дугаар анги	Орхон аймаг /Эрдэнэт/
20	Зэвсэгт хүчний 330 дугаар анги	Дархан-Уул аймаг /Дархан/
21	Зэвсэгт хүчний 322 дугаар салбар	Дархан-Уул аймаг /Дархан/
		45 хоног

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

“ЗӨВ ИРГЭН-ШИНЭ ҮЕИЙН ЦЭРЭГ ХАМТЫН ХӨГЖИЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” болон “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд чиглэгдсэн зорилго, зорилтот арга хэмжээнүүд нь энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болно.

1.2. Монгол Улсын Зэвсэгт хүчинд цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг сайжруулах, шинэчлэх чиглэлээр хэрэгжүүлж ирсэн ажлын туршлага, сургамжаас дүгнэхэд Зэвсэгт хүчний хөгжилд цэргийн алба хаагчийн чадавх тэргүүн зэргийн ач холбогдолтой тул түүний үндэс болсон цэргийн алба, сахилга зохион байгуулалтын ажлыг хүний хөгжилд тулгуурлаж тэдний мэдлэг, чадварыг албаны ёс зүй, эрх зүйн ухамсар, итгэл үнэмшил, бие сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудалтай цогц байдлаар зохион байгуулах шаардлага бий болжээ. Хүний хөгжлийн асуудал нь нийгмийн олон талт хүчин зүйлээс хамааралтай, “зөв хүн болгон төлөвшүүлэх”-д суурилсан урт хугацааны бодлогын үр дүнгээр хэмжигддэг онцлогийг харгалзан энэ чиглэлээр Зэвсэгт хүчний дээд удирдлагаас санаачлага гарган төр, нийгмийн бүхий л боломжийг нэгтгэн хамтран ажиллах шаардлага бий болоод байна.

1.3. Батлан хамгаалахын болон Зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, стратегийн баримт бичгүүдэд цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шинэчлэх, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх асуудал тусгагддаг боловч хөрөнгө, санхүүгийн боломж, зарим талаар зохион байгуулалтаас хамаарч үр дүн хүссэн хэмжээнд гараагүй нь хүний хөгжлийн асуудалтай цогц байдлаар уялдуулсан урт хугацааны бодлого тодорхойлсон баримт бичиггүй байсантай холбоотой.

1.4. “Зөв иргэн-шинэ үеийн цэрэг хамтын хөгжил” дэд хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх) нь хүүхэд, залуусыг эх орноо хамгаалах, улс орныхоо хөгжил, дэвшилд хувь нэмэр оруулах хариуцлагатай зөв бие хүн болгон төлөвшүүлэхэд Зэвсэгт хүчин төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг 2030 он хүртэл хөгжүүлэх зорилго, зорилт, арга замыг тодорхойлсон урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Хоёр. Тулгарч буй сорилт

2.1. Цэргийн албанд гэмт хэрэг, сахилга ёс зүй, хүний эрхийн зөрчил нэмэгдэх нь албаны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж иргэний нийгмийн зүгээс Зэвсэгт хүчинд хандах хандлага, итгэл буурах улмаар Монгол Улсын батлан хамгаалах хүчин чадал сулрах эрсдэл,

2.2. Зэвсэгт хүчний үйл ажиллагаа төрийн нууцтай нягт холбоотой, улс төрөөс ангид байх зарчим, хуулийн хориг ихтэй байдал нь тулгарч буй бэрхшээл, асуудлыг

нээлттэй илэрхийлэх, улс төр, нийгмийн хэлэлцүүлэг өрнүүлэх, дэмжлэг авах боломж хаагдмал,

2.3. Цэргийн алба хаагчид хууль эрх зүйн ухамсар, соёл төлөвшүүлэх, цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үр дүнтэй механизм бүрдээгүйгээс гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах үйл ажиллагаа, хяналт сул,

2.4. Цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй цэргийн цагдаагийн өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь цаг үе, нийгмийн шаардлагыг хангахгүй байгаа,

2.5. Цэргийн ангийн байрлалд болон цэргийн алба хаагчаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг Зэвсэгт хүчин өөрөө хэрэг бүртгэх эрхгүйгээс цагдаа, хууль хяналтын байгууллагаас шалгахдаа үзлэг, нэгжлэг хийх зэргээр цэргийн байгууллагын нууц задрах, шалгаж буй албан тушаалтан нь цэргийн мэргэжилгүй тул хэрэг, зөрчлийг буруу ойлгож шалгаж шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгааныг бодитой тодорхойлж арилгуулах ажил дорвитой хийгддэггүй,

2.6. Цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад удирдах бүрэлдэхүүний манлайлал, мэдрэмж, шинэ хандлага, сэтгэлгээ шууд хамааралтай тул уламжлалт сэтгэлгээг өөрчлөх зэрэг сорилт тулгарч байна.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмуудыг баримтална:

3.1.1. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлттэй уялдсан байх;

3.1.2. Бодитой, үндэслэл бүхий судалгаа, шинжилгээ, тооцоонд тулгуурласан байх;

3.1.3. Хүний хөгжлийн асуудалд суурилсан байх;

3.1.4. Зэвсэг хүчин төр, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллахдаа төрийн болон албаны нууцыг хамгаалах;

3.1.5. Шаардагдах төсөв, хөрөнгөөр хангагдсан байх;

3.1.6. Бодлого, үйл ажиллагааны залгамж, тогтвортой байдлыг хангах.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4.1. Хөтөлбөрийн зорилго нь хүүхэд, залуучуудыг багаас нь эх оронч, хүнлэг, хууль ёсыг дээдлэх үзэлтэй, ёс зүй, харилцаа хандлагын зөв төлөвшилтэй хүн болгоход гэр бүлийн орчноос эхлээд бүх шатны боловсрол, хүмүүжлийн байгууллага, төр, иргэний нийгмийн байгууллагуудтай Зэвсэгт хүчин хамтран ажиллаж цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шинэ хандлагаар тодорхойлж, иргэн-цэргийн харилцааны шинэ эрин үеийг хөгжүүлж, цэргийн алба хаагчийн хөгжлийг хангахад оршино.

4.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ:

4.2.1. Иргэн цэргийн албыг хаахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон шинэчлэх;

4.2.2. Хүүхэд, залууст балчир наснаас нь эхлэн зөв төлөвшил, цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг олгоход төр, иргэний нийгмийн бүх шатны байгууллагатай хамтран ажиллах;

4.2.3. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шинэ хандлагаар тодорхойлж, цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бие даасан мэргэжлийн албыг бэхжүүлэх;

4.2.4. Зэвсэгт хүчний хүний нөөцийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх;

4.2.5. Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо, сургалт явуулах арга хэлбэрийг боловсронгуй болгох, цэргийн урлагийг хөгжүүлэх;

4.2.6. Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгаалал, ажлын байрны гэрчин нөхцөлийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

5.1. Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны болон Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээнд нийцүүлэн богино /2021-2022 он/, дунд /2023-2026/, урт хугацаа /2027-2030/-нд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээ

6.1. Богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1.1. Иргэн цэргийн алба хаах харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээ, цэргийн албаны онцлогт нийцүүлэн боловсронгуй болгож шинэчлэх;

6.1.2. Цэргийн аюулгүй байдлыг хангах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, түүнийг бууруулахад чиглэсэн судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

6.1.3. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, цэргийн байгууллагад цахим хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

6.1.4. Зэвсэгт хүчний хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох;

6.1.5. Иргэд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон сургалт хүмүүжлийн байгууллагатай хамтран цэрэг-иргэний харилцаа ба улс орны аюулгүй байдал, бүтээн байгуулалтад оруулах хувь нэмрийг сурталчилж, төрийн болон албаны нууцаас бусад мэдээллийг нээлттэй солилцох, цэрэг-эх оронч үзэл хүмүүжил, төлөвшүүлэх;

6.1.6. Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн мэргэжил, мэргэшил, ур чадварын шалгуур үзүүлэлтэд үнэлэлт, дүгнэлт хийх түвшин тогтоох үзлэг явуулж, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх;

6.1.7. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний албан тушаалтанд тавигдах шаардлага, тодорхойлолтыг шинэчлэн баталгаажуулах;

6.1.8. Цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр цэргийн цагдаагийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;

6.1.9. Цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах ажлыг нэгтгэл, анги, байгууллага, салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлж, цэргийн аюулгүй байдлыг хангахад мэргэжлийн бодитой дэмжлэг үзүүлэхэд цэргийн цагдаагийн нэгжийг мэргэшүүлж бэхжүүлэх;

6.1.10. Цэргийн цагдаагийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэгдсэн сургалт бэлтгэлийн стандарт, хөтөлбөр, шаталсан сургалтын тогтолцоо, орчныг бий болгох.

6.2. Дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

6.2.1. Цэргийн захиргааны удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг төлөвшүүлж, эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх;

6.2.2. Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

6.2.3. Зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн алба хаагчийн тооны дээд хязгаарыг Монгол Улсын Их Хурлаар шинэчлэн тогтоох;

6.2.4. Цэргийн сургалтын материаллаг баазыг орчин үеийн техник, технологи, цэргийн урлагийн хувьсал, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх;

6.2.5. Хугацаат цэргийн алба хаасан байлдагч, түрүүч нарт мэргэжил олгох, нийгмийн хамгааллыг сайжруулах;

6.2.6. Иргэдэд эх орон, ард түмнийхээ түүх, соёл, уламжлал, зан үйлийг таниулан сурталчлах, Монгол цэргийн дайчин замнал, төрийн цэргийн байгууллын үүрэг, зорилт, цэргийн хөдөлмөрийн онцлог, ач холбогдлыг таниулах замаар тэдний цэргийн албыг биеэр хааж, иргэний цэргийн үүргээ биелүүлэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх;

6.2.7. Их, дээд сургуулиудад "Цэргийн тэнхим" байгуулж, оюутан, суралцагсдад цэргийн хэргийн мэдлэг, цэрэг эх оронч үзэл, хүмүүжил, иргэний хамгаалалтын мэдлэг олгох;

6.2.8. Офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчийн хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмээр хүлээсэн үүргээ зөрчсөн, дүрмийн бус харьцааны зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлагын үр дүнтэй зохицуулалтыг бий болгох;

6.2.9. Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын албан шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоож мөрдүүлж, төрийн албаны мөрит зарчмын дагуу хүний нөөцийн менежментийг сайжруулах;

6.2.10. Цэргийн цагдаагийн мэргэжил олгох үндсэн сургалт явуулах бэлтгэлийг шат дараатайгаар хангаж Үндэсний батлан хамгаалахын их сургуульд "Цэргийн цагдаагийн анги" нээж офицер, ахлагч ангиллаар сургах.

6.3. Урт хугацаанд хэрэгжүүлэх арга, хэмжээ

6.3.1. Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, түүний удирдлага, иргэн цэргийн алба хаахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг түүний чиг үүрэг, нийгмийн төлөвшил, улс орны эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн шинээр болон шинэчлэн тогтоох;

6.3.2. Цэргийн албанд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг цэргийн цагдаа шалган шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль хяналтын бусад байгууллагуудтай хамтран ажиллах тогтолцоог үе шаттайгаар бий болгох;

6.3.3. Цэргийн алба хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг шинэчлэн сайжруулж, эрх зүйн ухамсартай, зөв боловсон дадалтай болгон төлөвшүүлэх;

6.3.4. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн цэргийн зориулалттай байрны багтаамж, тоог нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаагчдын амралтын байранд шинэчлэлт хийж, нэг тасалгаанд 4 хүртэлх цэргийн алба хаагч амьдрах, алба хаах барилгын шийдлийг бий болгох;

6.3.5. Зэвсэгт хүчний цэргийн сургалтын агуулга, зохион байгуулалт, арга зүйг орчин үеийн хосолмол дайнд бэлтгэхэд чиглүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх;

6.3.6. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний үндсэн цалинг нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо судалгааг боловсруулж Монгол Улсын Засгийн газраар шийдвэрлүүлэх;

6.3.7. Нэгтгэл, ангийн штаб, салбар, салааны удирдлагын нэгжийн чиг үүргийг шинээр тодорхойлж, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг хүний хөгжлийн асуудалд суурилж шинэ шаардлага хэвшүүлэх;

6.3.8. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчид, иргэдтэй явуулах төр, цэргийн уламжлал, эх оронч хүмүүжил, сэтгэл зүйн хангалт, эрх зүйн мэдлэгийн хичээлийн хөтөлбөр, стандартыг шинэчлэх;

6.3.9. Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техник, сургалтын материаллаг баазыг шинэчлэх, сэргээн сайжруулах;

6.3.10. Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний зарим хэлбэрийг хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх тогтолцоо, зохицуулалтыг боловсронгуй болгох;

6.3.11. Цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад зориулсан төсөвтэй болж,

цэргийн сургалт бэлтгэлийн чанар, үр дүнг нэмэгдүүлэх.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний ёс зүй, сахилга, хариуцлага сайжирч цэргийн алба хаагчийн хөгжил, хүний эрхийг хангаж дээдэлсэн цэргийн алба төлөвшиж, цэрэг-иргэний харилцаа шинэ шатанд бэхэжнэ.

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт, хяналт-шинжилгээ

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх арга хэмжээ, байгууллагын стратегийн болон энэхүү дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлнэ.

8.2. Баримт бичигт Монгол Улсын Засгийн газар хяналт-шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгнө.

---oOo---

"ЗӨВ ИРГЭН-ШИНЭ ҮЕИЙН ЦЭРЭГ ХАМТЫН ХӨГЖИЛ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн зорилт	Хийгдэх ажлууд	Хэрэгжүүлэгч (resource)	Санхүүжилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Хамтран хэрэгжүүлэгч
1		Иргэн цэргийн алба хаах харилцааг хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	Хугацаат цэргийн албанд татагдан ирэх иргэдийн тоог бууруулахгүй байх	Цэрэг татлага бүрээр тодорхой бүрэлдэхүүн ямар нэгэн байдлаар чөлөөлөгдөж байна.	Хугацаат цэргийн албанд татагдах иргэдийн хүсэл эрмэлзэл нэмэгдэж, алба хаах хугацааны эрх зүйн байдал сайжирна.	БХЯ, ХЗДХЯ
2	Иргэн цэргийн албыг хаахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон шинэчлэх	Сахилга, хариуцлагын ноцтой гаргасан ЦАХ-ийг халах зохицуулалтыг Цэргийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд нэмэлтээр тусгах	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	ЦАХ нэг бүр алба хаах хугацаандаа сахилга, хариуцлагын зөрчил гаргахгүй байх	Нэг удаагийн ноцтой зөрчил гаргасан ЦАХ-д хүлээлгэх хариуцлага тодорхойгүй	ЦАХ-дын хариуцлага, сахилга бат сайжирна.	БХЯ, ХЗДХЯ
3		Зэвсэгт удирдлагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	Албаны хариуцлагыг дээшлүүлэх	Зэвсэгт хүчинд 22.4 хувийг нэн ядуу амьдарч буй гэр бүлээс ирсэн ЦАХ эзэлж байна.	ЦАХ-дын нийгмийн хамгаалал сайжирч, удирдлагын тогтолцоо боловсронгуй болно.	БХЯ, ХЗДХЯ

	нэмэлт, өөрчлөлт оруулах			Санхүүжилт шаардлагагүй	Албаны хариуцлагыг дээшлүүлэх	Нэгтгэл, ангийн штаб, салбарын зарим удирдлагын албандаа хандах хариуцлага сул байна.	Цэргийн алба хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.	БХЯ
4	Нэгтгэл, ангийн штаб, салбар, салааны удирдлагын чиг үүргийг шинээр тодорхойлж, албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	Албаны хариуцлагыг дээшлүүлэх	Нэгтгэл, ангийн штаб, салбарын зарим удирдлагын албандаа хандах хариуцлага сул байна.	Цэргийн алба хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.	БХЯ
5		Зэвсэгт цэргийн хаагчдын шалгуур шинэчлэн мөрдүүлж, албаны зарчмын дагуу хүний нөөцийн менежментийг сайжруулах	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	Албаны хариуцлагыг дээшлүүлэх	Нэгтгэл, ангийн штаб, салбарын зарим удирдлагын албандаа хандах хариуцлага сул байна.	Цэргийн алба хэвийн явагдах нөхцөл бүрдэнэ.	БХЯ
6	Хүүхэд, залууст балчир наснаас нь эхлэн зөв төлөвшил, "цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг олгоход төр, иргэний нийгмийн бүх шатны байгууллагатай хамтран	Цэргийн хаагчийн үнэт зүйлийг олон нийтэд ил тод болгох, сурталчлан таниулах, Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхийн тулд соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах	- Бүх шатны захирагч дарга нар - Цэргийн алба хаагч нэг бүр - Төр, иргэний нийгмийн байгууллагууд	Санхүүжилт шаардлагагүй	Зөв төлөвшил, цэрэг-эх оронч үзэл, хүмүүжилтэй байх	Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхийн тулд соён гэгээрүүлэх ажлын тоог нэмэгдүүлэх	Монгол ардын дунд "Монгол цэрэг"-ийн нэр хүндийг өргөж, иргэдийн бахархлыг төрүүлнэ.	БХЯ, "Ахмадын хороо", "МЦНХ, Генералууд болон Монгол хурандаа нийгэмлэг
7	Иргэдэд эх орон, ард түмнийхээ түүх, соёл, хамтран	Иргэдэд эх орон, ард түмнийхээ түүх, соёл, хамтран	ЗХЖШ, төрлийн	Урсгал зардлаас	Арга хэмжээ зохион	Цэрэг татлагад	Зэвсэгт хүчинд итгэх	Цэргийн штаб

	<p>ажиллах</p>	<p>уламжлал, зан үйлийг таниулан сурталчлах, Монгол цэргийн дайчин замнал, төрийн цэргийн байгууллын үүрэг, зорилт, цэргийн хөдөлмөрийн онцлог, ач холбогдлыг таниулах замаар тэдний цэргийн албыг биеэр хааж, иргэний цэргийн үүргээ биелүүлэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх</p>	<p>цэргийн командлал</p>		<p>байгуулагдсан байх</p>	<p>цэргийн насны залуучуудыг журмын дагуу татаж байгаа боловч зарим үед хяналтын тоонд хүрэхгүй тохиолдол гарч байна. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсан.</p>	<p>иргэдийн итгэл нэмэгдэнэ</p>	<p>БХЯ</p>
<p>8</p>	<p>Их, дээд сургуулиудад “Цэргийн тэнхим” байгуулж, оюутан, суралцагсдад цэргийн хэргийн мэдлэг, цэрэг эх оронч үзэл, хүмүүжил, иргэний хамгаалалтын мэдлэг олгох</p>	<p>ЗХЖШ, төрлийн цэргийн командлал</p>	<p>Урсгал зардлаас</p>	<p>Их дээд сургуульд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байх</p>	<p>Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсан. Залуучуудын эх оронч үзэл дутмаг байна.</p>	<p>Хүүхэд залуучуудын эх оронч үзэл, хүмүүжилд ахиц гарна</p>	<p>БХЯ</p>	<p>ЭМЯ, БХЯ, ЦЕГ, МЭХ</p>
<p>9</p>	<p>Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалт явуулах</p>	<p>- Мэргэшсэн сургагч багш - Сургалтын хөдөлгөөнт бүлэг - Сургуулийн өмнөх, ЕБС, их дээд</p>	<p>Санхүүжилт шаардлагагүй</p>	<p>ЦАХ бие бялдрын хувьд эрүүл чийрэг, өв тэгш байх</p>	<p>2020 оны II ээлжийн цэргийн алба хаахаар эрүүл мэндийн үзлэгээр орсон</p>	<p>Хүн нэг бүр хүчирхийллээс ангид байж, бэлгийн болон нөхөн үржихүйн хувьд эрүүл байна.</p>	<p>ЭМЯ, БХЯ, ЦЕГ, МЭХ</p>	<p>ЭМЯ, БХЯ, ЦЕГ, МЭХ</p>

		сургуулийн удирдлага			залуусын 26.9 хувь эрүүл мэндээр тэнцээгүй. Үүнээс 10 хувь сэтгэцийн эмгэгтэй байсан.				
10	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг шинэ хандлагаар тодорхойлж, цэргийн албанд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, цэргийн ёс зүй, сахилга дэг журам сахиулах, цэргийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бие даасан мэргэжлийн	Цэргийн аюулгүй байдлыг хангах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх эрчимжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, түүнийг бууруулахад чиглэсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	Цэрэг аюулгүй байх нөхцөл бүрдэнэ.	2021 оны 03 дугаар сард 1 ХЦАХ амь насаа алдсан гэмт хэрэг гарсан.	Цэргийн алба сахилга дэг журам бэхэжсэн байна	БХЯ	
11	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, цэргийн байгууллагад цахим хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах	Хүчний эрх, эрх чөлөө, Жендерийн эрх тэгш байдлын тухай сургалт зохион байгуулах чадавх	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, бүх шатны дарга нар	Улсын төсвөөр	Цэргийн албаны өдөр тутмын үйл ажиллагаанд давхар хяналт тавих боломж бүрдэнэ.	2022 оны 03 дугаар сард 1 ХЦАХ амь насаа алдсан гэмт хэрэг гарсан.	Цэргийн алба сахилга дэг журам бэхэжсэн байна	БХЯ	
12	Хүний эрх, эрх чөлөө, Жендерийн эрх тэгш байдлын тухай сургалт зохион байгуулах чадавх	Хамтын ажиллагаатай гадаад улсын тусламж дэмжлэгээр	ЦАХ-дын хоорондын харилцаанд эерэг уур амьсгалтай	Хүн нэг бүр хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, гэмт хэрэг, осол,	2021 оны 03 дугаар сард 1 ХЦАХ амь насаа алдсан гэмт хэрэг			ГХЯ, БХЯ, ХЭҮК, ЖҮХ	

	албыг бэхжүүлэх	бүхий сургагч багш нарыг нэн тэргүүнд бэлтгэн сургалт тасралтгүй зохион байгуулах	мэргэжилтнүүд - Сургалтын хөдөлгөөнт бүлэг Нэгтгэл, анги салбарын сургалтын офицер		байх	гарсан.	зөрчилгүй хамт олон болно.	
13	Тогтмол танилцуулга хийх, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	Бүх шатны захирагч дарга нар	Санхүүжилт шаардлагагүй	Гэмт хэрэг, осол зөрчилгүй байх	Гэмт хэрэг, осол зөрчилгүй гарсан.	2021 оны 03 дугаар сард 1 ХЦАХ амь насаа алдсан гэмт хэрэг гарсан.	Гэмт хэрэг, осол зөрчилгүй гаргахгүй байна.	БХЯ, ЦЕГ
14	Нийгэм, хүрээлэн буй орчин, хамт олны дунд ЦАХ-дын хоорондын харилцаанаас үүдэлтэй үүсэн гарах стресс, депрессыг хэрхэн арилгах талаар судалгаа явуулж, холбогдох сургалт зохион байгуулах	Бүх шатны захирагч дарга нар, томилгоот сэтгэл зүйч нар	Санхүүжилт шаардлагагүй	Стрессгүй хамт олон байх	Стрессгүй, хамт олны зөрэг уур амьсгалыг бүрдүүлсэн байна	2021 оны эхний 3 сарын байдлаар ЦАХ-дын дундаас амиа хорлох гэсэн оролдлого хийгээгүй болно.	Стрессгүй, хамт олны зөрэг уур амьсгалыг бүрдүүлсэн байна	БХЯ, ЭМЯ
15	Ард иргэд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагатай хамтран Зэвсэгт хүчний ажиллагааг сурталчилж, цэрэг-эх оронч үзэл хүмүүжил, төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Бүх шатны захирагч дарга нар, хэвлэл мэдээллийн офицер, ахлагч нар	Санхүүжилт шаардлагагүй	Арга хэмжээ зохион байгуулагдсан байх	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр Зэвсэгт хүчний нэр хүндийг унагаж, нийгмийг талцуулсан байдалтай	Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нээлттэй байна	Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нээлттэй байна	ТЦК

16	ЗХЖШ-т шинээр байгуулсан албаны цэргийн албыг бэхжүүлэх	Бүх шатны захирагч дарга, цэргийн албаны болон цэргийн цагдаагийн офицер, ахлагч нар	Санхүүжилт шаардлагагүй	Цэргийн албанд сахилга дэг журмын шинэ орчин бүрдэх	байна. 2020 оны 12 дугаар сард ЗХЖШ-т Цэргийн албаны хэлтсийг байгуулсан.	Бие бялдар, сэтгэл зүйн хувьд осол, зөрчил гаргаагүй хамт олон болно.	МБХЯ
17	Зэвсэгт хүчний хүний нөөцийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх	Зэвсэгт хүчний нөцийн баримт шинэчлэлийг эрчимжүүлж, нөцийн албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх	Бүх шатны захирагч дарга, хүний нөцийн офицер, ахлагч нар	Санхүүжилт шаардлагагүй	Гэмт хэрэг, осол зөрчилгүй ЦАХ-даас бүрдсэн хамт олон байх	Хүний нөцийн бодлого зөв болж, сонгон шалгаруулалт, томилгоо зөв хийгдэнэ.	БХЯ
18	Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх	Манлайлал, удирдлагын чиглэлийн сургалт явуулах	Бүх шатны захирагч дарга нар - Мэргэшсэн сургагч багш - Цэргийн бэлтгэл офицер, ахлагч нар зэрэг зочин-багш	Санхүүжилт шаардлагагүй	Офицер, ахлагч нэг бүр манлайлагч байх	Манлайллын чиглэлийн сургалт хангалттай хэмжээнд зохион байгуулагдаа гүй.	ЦАХ нэг бүр манлайлал, удирдлагын чиглэлийн сургалтад хамрагдсан байна. БХЯ, ГХЯ,
19	Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх	Бусдад дуурайлал болохуйц "ЗАГВАР ЖИШЭЭ - ROLE MODEL" ЦАХ-даар зочин-багш хэлбэрээр урин	- Цэргийн бэлтгэл офицер, ахлагч нар зэрэг зочин-багш	Санхүүжилт шаардлагагүй	Тэргүүний ЦАХ-даас суралцсан байх	"ЗАГВАР ЖИШЭЭ - ROLE MODEL" ЦАХ-даар зочин-багш	Зэвсэгт хүчинд "ЗАГВАР ЖИШЭЭ - ROLE MODEL" ЦАХ болон БХЯ, "Ахмадын хороо", МЦНХ, Генералууд болон

23	урлагийг хөгжүүлэх	дүнг нэмэгдүүлэх Цэргийн сургалтын материаллаг баазыг орчин үеийн техник, технологи, цэргийн урлагийн хувьсал, өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэх	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Улсын төсөв 3,2 тэрбум төгрөг	Шинэчлэгдсэн байх	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Сургалт бэлтгэл дээшилнэ	БХЯ
24		Зэвсэгт хүчний цэргийн сургалтын агуулга, зохион байгуулалт, арга зүйг орчин үеийн хосолмол дайнд бэлтгэхэд чиглүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх.	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Улсын төсөв	ЦАХ тайван болон байлдааны цагт үүрэг гүйцэтгэх чадвар өндөр байх	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Сургалтын тогтолцоо шинэчлэгдэнэ	БХЯ, БСШУСЯ
25		Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчид, иргэдтэй явуулах төр, цэргийн уламжлал, эх оронч хүмүүжлийн хичээлийн хөтөлбөр, стандартыг шинэчлэх	ЗХЖШ, төрлийн цэргийн командлал	Санхүүжилт шаардлагагүй	ХЦАХ болон иргэдтэй явуулах	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Хөтөлбөр шинэчлэгдэнэ	БХЯ, БСШУСЯ
26		Ур чадварт суурилсан ярилцлага хийж, журам үнэлгээний боловсруулан, ЦАХ нэг бүрийн албан тушаал дэвших тугам ашиглах	- Бүх шатны захирагч дарга нар - Мэргэшсэн сургагч багш	Санхүүжилт шаардлагагүй	ЦАХ нэг бүр мэргэжлийн өндөр мэдлэг, дадлага, ур чадвартай байх	Ур чадварт суурилтуулан нарийвчилсан үнэлгээний журам байхгүй.	ЦАХ-дын албан тушаал ахихад уг журмыг ашиглан, цол ахих тугам хариуцлагатай байх зарчим үйлчилнэ.	БХЯ
27		Цэргийн алба хаагч хоорондын	- Бүх шатны захирагч	Санхүүжилт шаардлагагүй	ЦАХ нэг харилцааны	ЦАХ нэг бүр харилцааны	ЦАХ хооронд, ахлах дарга	БХЯ, ГХЯ

		харилцааны асуудалд дүн шинжилгээ хийж, бодит тооцоо, судалгаагаар тайлан боловсруулж, үр дүнг тооцож байх	дарга нар, томилгоот сэтгэл зүйч нар - Гадаад улсын цэргийн мэргэжилтнүү дийн тусламжтайга ар - Сургалтын хөдөлгөөнт бүлэг		өндөр чадавхтай байх	чадварт бүрэн суралцаагүй байна.	захирагдагсад хооронд, ЦАХ-энгийн иргэдийн хооронд харилцааны зөрчилгүй хамт олон болно	ХЯ
28		ЦАХ-дын тайван болон байлдааны цагт үүрэг гүйцэтгэх боломжийг үнэлэх журамд хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдалтай холбоотой заалтууд нэмэх	- Бүх шатны захирагч дарга нар - Нэгтгэл, анги салбарын сургалтын офицер - Мэргэшсэн сургагч багш	Санхүүжилт шаардлагагүй	ЦАХ нэг бүр мэргэжлийн цэргийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах	2021 оны 03 дугаар сард 1 ХЦАХ амь насаа алдсан гэмт хэрэг гарсан.	Зэвсэгт хүчин өндөр мэдлэг, дадлага, ур чадвартай "МЭРГЭЖЛИЙН ЦЭРЭГ" тэй болно.	БХЯ
29	Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, ажлын байрны орчин нөхцөлийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн санхүүгийн чиглэлээр сургалт явуулах	Бүх шатны захирагч дарга нар Нэгтгэл, анги, салбарын санхүүгийн офицер Мэргэжлийн газрын зочин-багш	Санхүүжилт шаардлагагүй	Залуу офицер, ахлагч нарын дунд гэр бүл салалтын тоог цөөлж, тогтвортой, орлоготой гэр бүлийн тоо нэмэгдсэн байх	Төрийн бодлогог дэмжих, хүн ам зүйн асуудлыг бэхжүүлэх, гэр бүл төлөвлөлт, өрхийн амьжиргааг дээшлүүлэх асуудалд дэмжлэг	Монгол Улсын хэмжээнд гэр бүл салалтын статистик үзүүлэлтийг багасгахад дэмжлэг үзүүлнэ.	БХЯ, ХНХЯ, ГБХЗХГ

30	Цэргийн хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулж, боловсон төлөвшүүлэх	Цэргийн алба ажиллаж, орчин шинэчлэн зөв байрны зориулалттай байрны багтаамж, тоог нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаагчдын амралтын байранд шинэчлэлт хийж, нэг тасалгаанд 4 хүртэлх цэргийн алба хаагч амьдрах, алба хаах барилгын шийдлийг бий болгох	Бүх шатны захирагч дарга нар	Улсын төсөв	800 цэргийн байр шинээр баригдах	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Цэргийн байр, казармын багтаамж нэмэгдэнэ	БХЯ, ТЦК
31	Зэвсэгт нэгтгэл, цэргийн зориулалттай байрны багтаамж, тоог нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаагчдын амралтын байранд шинэчлэлт хийж, нэг тасалгаанд 4 хүртэлх цэргийн алба хаагч амьдрах, алба хаах барилгын шийдлийг бий болгох	Зэвсэгт хүчний ангийн цэргийн зориулалттай байрны багтаамж, тоог нэмэгдүүлж, хугацаат цэргийн алба хаагчдын амралтын байранд шинэчлэлт хийж, нэг тасалгаанд 4 хүртэлх цэргийн алба хаагч амьдрах, алба хаах барилгын шийдлийг бий болгох	Бүх шатны захирагч дарга нар	Улсын төсөв	Хугацаат цэргийн алба хаагчдын алба хаах нөхцөл дээшлэх	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Цэргийн байрны стандарт шинэчлэгдсэн байна.	БХЯ
32	Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Бүх шатны захирагч дарга нар	Улсын төсөв 435 тэрбум төгрөг	2021 онд: шинээр 3, засвар- 18; 2022-2024 онд: шинээр 18, засвар- 58; 2024-2030 онд: шинээр 14, засвар- 37 барилга	Тооцоо судалгаа хийгдсэн.	Бие бүрэлдэхүүний нийгмийн хамгаалал, ажлын байрны орчин нөхцөл сайжирсан байна.	БХЯ
33	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний үндсэн цалинг нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо судалгаа /2021 оны I	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний үндсэн цалинг нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо судалгаа /2021 оны I	Бүх шатны захирагч дарга нар	Улсын төсөв	Бие бүрэлдэхүүний нийгмийн хамгаалал сайжруулах	Холбогдох тооцоог боловсруулж байна.	Бие бүрэлдэхүүний цалин хангамж өснө	БХЯ

	<p>улирлын байдлаар 75,7 хувь нь боломжийн амьдралтай, 22,5 хувь нь бага орлоготой, 1,4 хувь нь ядуу, 0,1 хувь нь нэн ядуу/-г боловсруулж Монгол Улсын Засгийн газраар шийдвэрлүүлэх</p>						
--	--	--	--	--	--	--	--

---000---

101

М Б

75



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2021 оны...дүгээр
сарын...өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Нэг талаас Зэвсэгт хүчний Жанжин штаб, нөгөө талаас Цагдаагийн Ерөнхий газар (цаашид "талууд" гэх)-ын хооронд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад дүрэм журам, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого "Алсын хараа 2050", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Засгийн газрын 2017 оны 127 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" бодлогын баримт бичигт тусгагдсан амар тайван, аюулгүй нийгмийн төлөө гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд, залуусыг эх орноо хамгаалах, улс орныхоо хөгжил, дэвшилд хувь нэмэр оруулах хариуцлагатай зөв бие хүн болгон төлөвшүүлэх ажлын хүрээнд энэхүү "Санамж бичиг"-ийг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санамж бичгийн зорилго нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний цэргийн цагдаагийн алба Цагдаагийн байгууллагын холбогдох албатай мэргэжлийн сургалт, бэлтгэл хийх, шаардлагатай үед харилцан ажиллах удирдлага, зохион байгуулалттай болох, хамтарсан ажиллагааны үед шаардлагатай туслалцааг үзүүлэхэд оршино.

1.2. Хамтын ажиллагаандаа Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгалаа олсон аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгыг эрхэмлэж, харилцан бие биеэ хүндэтгэн төрийн болон албаны нууцыг хадгалах, бодлого, үйл ажиллагааны залгамж, тогтвортой байдлыг хангах зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Хамтын ажиллагааны үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Талуудын хамтын ажиллагаа нь төлөвлөлт-нэгдсэн ойлголцол, сургалт, бэлтгэл, хамтарсан ажиллагаа, мэдээлэл солилцох, харилцан дэмжлэг үзүүлэх болон бусад ажиллагааны чиглэлээр тодорхойлогдоно.

2.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын зүгээс:

2.2.1. Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн цагдаагийн үүрэг гүйцэтгэх Цагдаа,

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын сургалт, бэлтгэлийг олон улсын ажиллагааны стандарт, хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулж мэргэшүүлэх;

2.2.2. Зэвсэгт хүчин болон төрийн цэргийн байгууллагад цэргийн сахилга, дэг журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий цэргийн цагдаагийн албыг богино хугацаанд бэхжүүлж шаардлагатай үед хуульд заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадамжтай болгох;

2.2.3. Зэвсэгт хүчний "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-өөс хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах;

2.2.4. Зэвсэгт хүчинд алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдаас Цагдаагийн байгууллагад ажиллах сонирхолтой алба хаагчийн судалгаа хийж цагдаагийн байгууллагад танилцуулан хамтарсан сургалт зохион байгуулах;

2.2.5. Гэмт хэрэгтэй тэмцэх, дэг журам сахиулах чиглэлээр шаардлагатай үед хуульд заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагад дэмжлэг үзүүлэх.

2.3. Цагдаагийн ерөнхий газрын зүгээс:

2.3.1. Цагдаагийн төв, орон нутгийн байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хэв журам хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээндээ Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбартай хамтран хэрэгжүүлэх чиглэлийг тусгайлан тусгаж харилцан ажиллах;

2.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам сахиулах эргүүл, хамгаалалт, нэгдсэн ажиллагааг цэргийн хүрээ, хотхоны хариуцлагын бүсийн нутаг дэвсгэрт цэргийн цагдаагийн салбартай хамтран гүйцэтгэх;

2.3.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журам хамгаалах чиглэлээр цэргийн анги, байгууллагад хууль тогтоомж сурталчлах, сургалт, зөвлөгөө өгөх;

2.3.4. Цэргийн цагдаагийн албыг бэхжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэхэд сургалт, дадлага, хамтарсан ажиллагаа зохион байгуулах, цагдаагийн байгууллагад ашиглагддаг аминд үл хүрэх зэвсэг, тусгай хэрэгслийн сургалтад дэмжлэг үзүүлэх;

2.3.5. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг Зэвсэгт хүчний цэргийн цагдаагийн албатай холбож, цахим мэдээллийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх.

Гурав. Талуудын нийтлэг, эрх үүрэг

3.1. Хамтын ажиллагааны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газрын дарга нар ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

3.2. Ерөнхий боловсролын сургууль болон сургалт, хүмүүжлийн бусад байгууллагатай хамтран хүүхэд, залуусыг эх оронч үндэсний үзэлтэй, хууль, хүний эрх зөрх чөлөөг дээдэлсэн зөв хүн болгон төлөвшүүлэх ажилд хамтарч, сургалт явуулах алба хаагч, багш нарын ур чадварыг сайжруулах, туршлага солилцох ажлыг зохион байгуулна.

3.3. Хамтарсан болон бүх төрлийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг шат дараалан авах, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, харилцан туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

3.4. Хоёр талын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

3.5. Амьнд үл хүрэх зэвсэг, тусгай хэрэгслийг ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын чиглэлээр гадаад орнуудын туршлага судлан сургалтад ашиглаж, нэвтрүүлнэ.

3.6. Талуудын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам сахилга хариуцлагыг бэхжүүлэх үйл ажиллагаа, сургалт, бэлтгэлийн явц, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашдын чиг хандлагыг тодорхойлон хамтын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

3.7. Талууд аливаа асуудлыг аль нэг талтайгаа урьдчилан тохиролцолгүйгээр олон нийтэд мэдээлэхгүй, тараахгүй байх үүргийг харилцан хүлээж, хамтарсан болон дангаар хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар мэдээлэл солилцоно.

3.8. Талууд "Санамж бичиг"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар тус тусын хэвлэл, мэдээллийн төв, цахим сайт, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон боломжит хэлбэрээр сурталчилна.

Дөрөв. Хэрэгжилтийг хангах

4.1. Энэхүү "Санамж бичиг"-ийн хэрэгжилтийн явц, биелэлтийг өөрсдийн чиг үүргийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн албаны хэлтэс, Сургалтын хэлтэс, Төрлийн цэргийн командлал, удирдах газар, Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн дарга нар тус тус хариуцна.

4.2. Санамж бичгийн хэрэгжилтийн үр дүнг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цагдаагийн Ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс хамтран дүгнэж жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор удирдлагад танилцуулна.

Тав. Бусад нөхцөл

5.1. Энэхүү "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа асуудлыг талууд зөвшилцлийн замаар, шуурхай шийдвэрлэнэ.

5.2. "Санамж бичиг"-т талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

5.3. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор харилцан тохиролцож, энэхүү “санамж бичиг”-т нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.4. Талуудын аль нэг тал хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй гэж үзвэл нөгөө тал нь “Санамж бичиг”-ээс татгалзах саналаа бичгээр гаргана.

5.5. Татгалзах саналыг хүлээн авснаас хойш нөгөө талдаа ажлын 5 хоногт багтааж хариу өгөөгүй тохиолдолд “Санамж бичиг”-ийг хүчингүй болсонд тооцно.

5.6. Талууд “Санамж бичиг”-ийн дагуу олж авсан нууцлалтай холбоотой мэдээ, мэдээллийг Талуудын удирдлагын зөвшөөрөлгүйгээр бусдад ашиглуулах, задруулахыг хориглоно.

5.7. Талууд энэхүү “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажилласан алба хаагчийг шагнаж, урамшуулж болно.

5.8. “Санамж бичиг”-ийг хоёр хувь үйлдэн, талууд тус бүр хувийг хадгална.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНЗОРИГ

Хаяг:
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө-51.

Утас/факс: (976-51) 265914
E-mail: gsmaf@mil.gov.mn
Website: www.gsmaf.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

Хаяг:
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо. Самбуугийн гудамж-18

Утас/факс: 70191087
E-mail: info@police.gov.mn
Website: www.police.gov.mn